

**ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2026 оны 3 дугаар сарын 31-ний өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-4
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	5-37

1. Сургуулийн орчны эрүүл мэнд, аюулгүй байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Т.Мөнхсайхан нарын 3 гишүүн 2025.12.31-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	6-37
---	------

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны
3 дугаар сарын 31-ний өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны дарга Б.Найдалаа ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 29 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 55.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 13 цаг 37 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Томилолттой: А.Ганбаатар, Ц.Мөнхтуяа;
Чөлөөтэй: Ц.Баатархүү, Б.Бейсен, Ш.Бямбасүрэн, М.Нарантуяа-Нара,
Г.Хосбаяр, М.Энхцэцэг;
Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Баясгалан, Б.Түвшин, Л.Энхнасан.

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун хэлэлцэх асуудлын 2 дугаарт байгаа Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг орон сууцжуулах талаар Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдад хандсан асуултын хариуг хэлэлцэхийг хойшлуулах, Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа хэлэлцэх асуудлын 3 дугаарт байгаа Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагааны талаар Эрүүл мэндийн сайдад хандсан асуултын хариуг хэлэлцэхийг хойшлуулах горимын саналыг тус тус гаргав.

Б.Найдалаа: Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулууны гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 5
Бүгд: 17
70.6 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Б.Найдалаа: Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 5
Бүгд: 17
70.6 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Горимын санал дэмжигдсэн тул дээрх асуудлуудыг хойшлуулахаар тогтов.

Нэг.Сургуулийн орчны эрүүл мэнд, аюулгүй байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Т.Мөнхсайхан нарын 3 гишүүн 2025.12.31-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Боловсролын яамны Ерөнхий боловсролын бодлого зохицуулалтын газрын дарга М.Цогзолмаа, мөн газрын шинжээч Д.Дуламсүрэн, мөн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын ахлах шинжээч Ч.Баярмаа, Бодлого, төлөвлөлтийн газрын шинжээч Э.Чойсүрэн,

С.Пүрэвсайхан, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирал Л.Баттөр, мөн газрын Нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийн газрын мэргэжилтэн Ч.Ариунболор, Анагаах ухааны доктор Д.Нарансүх, О.Чимэдсүрэн, Хууль зүйн ухааны доктор Б.Оюунжаргал, Д.Ганхүрэл, Удирдахуйн ухааны доктор М.Намхайринчэн, Судлаач С.Энхцолмон, Улсын Их Хурлын гишүүний зөвлөх Б.Буянтогтох нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, Зөвлөх Б.Мажигсүрэн, референт Б.Энхмаа нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Т.Мөнхсайхан танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар, Д.Ганмаа, Д.Рэгдэл, О.Саранчулуун, Д.Бум-Очир, Ж.Галбадрах, Б.Найдалаа, М.Ганхүлэг, Х.Болормаа, Б.Хэрлэн нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Т.Мөнхсайхан, Боловсролын яамны Ерөнхий боловсролын бодлого зохицуулалтын газрын дарга М.Цогзолмаа, мөн газрын шинжээч Д.Дуламсүрэн, Анагаах ухааны доктор Д.Нарансүх, О.Чимэдсүрэн, Хууль зүйн ухааны доктор Д.Ганхүрэл, Улсын Их Хурлын гишүүний зөвлөх Б.Буянтогтох нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Ганмаа, Д.Рэгдэл, Б.Найдалаа нар үг хэлэв.

Б.Найдалаа: Сургуулийн орчны эрүүл мэнд, аюулгүй байдлын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 5
Бүгд: 18
72.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн:

Б.Найдалаа: 1.Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 5
Бүгд: 18
72.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтуяагийн “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, 77.8 хувийн саналаар дэмжсэнд тооцов.

2.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 4
Бүгд: 18
77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 4
Бүгд: 18
77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 33 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 56 минут үргэлжилж, 29 гишүүнээс 18 гишүүн хүрэлцэн ирж, 62.1 хувийн ирцтэйгээр 15 цаг 33 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН
БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Б.НАЙДАЛАА

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ГАЗРЫН
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

2026 оны 3 дугаар сарын 31-ний өдөр, Мягмар гараг
Төрийн ордон “Үндсэн хууль” танхим
13 цаг 37 минут.

ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Найдалаа: Сайн байцгаана уу. Өнөөдрийн Хүний хөгжил, нийгмийн нийгмийн бодлогын байнгын хорооны хуралд хүрэлцэн ирсэн гишүүдийнхээ өдрийн амар амгаланг айлтгая. Өнөөдрийн Байнгын хорооны хуралд ирвэл зохих 29 гишүүнээс 55,2 хувь хүрэлцэн ирж, ирц бүрдсэн байна.

Иймд Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны 2026 оны 3 сарын 31-ний өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу хуралдаанд хүрэлцэн ирсэн болон ирээгүй гишүүдийг танилцуулъя. Ирсэн гишүүдийг танилцуулъя. Аюушийн Ариунзаяа, Дуламын Бум-Очир, Мөнгөнцогийн Ганхүлэг, Бадрахын Найдалаа, Мягмардашийн Сарнай, Сүхбаатарын Эрдэнэбат, Дамбын Батлут, Жанчивын Галбадрах, Сархадын Зулпхар, Дүгэрийн Рэгдэл, Бадарчийн Хэрлэн, Хөххүүгийн Болормаа, Даваасамбуугийн Ганмаа, Тогтмолын Мөнхсайхан, Отгоны Саранчулуун, Доржзовдын Энхтуяа нарын гишүүд хүрэлцэн ирж, Байнгын хорооны хуралдааны ирц бүрдсэн байна.

Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэхээр товд орсон байгаа.

1 дүгээр асуудал Улсын Их Хурлын гишүүн Т.Мөнхсайхан, М.Мандхай, Л.Энх-Амгалан нараас өргөн мэдүүлсэн Сургуулийн орчны эрүүл мэнд, аюулгүй байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулна.

2 дугаар асуудал Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуунаас Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг орон сууцжуулах талаар Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдад хандсан асуулгын хариуг хэлэлцэнэ.

3 дугаар асуудал Улсын Их Хурлын гишүүн Ц.Баатархүүгээс Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагааны талаар Эрүүл мэндийн сайдад хандсан асуулгын хариуг хэлэлцэхээр байгаа.

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүд байна уу. Саранчулуун гишүүн.

О.Саранчулуун: Сайн байна уу. Хэлэлцэх асуудлыг нэмэлт дэлгэрэнгүй мэдээлэл авахтай холбоотойгоор 1 дүгээрт, 2 дугаарт нь яг энэ цаг үеийн байдалтай холбоотойгоор дахин хойшлуулаад, дараагийн 7 хоногт илүү дэлгэрэнгүйгээр ярилцъя гэсэн ийм саналтай байна. Тэгэхээр хэлэлцэх асуудлыг хойшлуулах саналтай байна. 2 дахь асуудлыг.

Б.Найдалаа: Ойлголоо. Баярлалаа. Тэгэхээр 2 дугаар асуудал буюу Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг орон сууцжуулах талаар Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдад хандсан Саранчулуун гишүүний асуултын хариуг

хэлэлцэхийг хойшлуулъя гэсэн санал байна. Тэгэхээр дэгийн дагуу энийг санал хурааж хойшлуулах ёстой байгаа. Нэмэлт мэдээлэл авна. Асуултыг дахиж тодруулж асууна. Дутуу мэдээлэл байна гэсэн үг. Ариунзаяа гишүүний микрофоныг өгье.

А.Ариунзаяа: Өнөөдөр 14 цагаас чуулганы нэгдсэн хуралдаан зарлагдсан байгаа. Тэгэхээр одоо 13 цаг 40 минут болж байна. 20 минутын хугацаа байгаад байна. Тэгэхээр хэлэлцэх асуудлаас энэ Баатархүү гишүүнээс Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагааны талаар Эрүүл мэндийн сайдад хандсан асуулгын хариултыг хэлэлцэх асуудал байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ магадгүй яг бас хэлэлцэж амжих болов уу, амжихгүй болов уу гэдэг ийм санал байгаад байна. Тэгэхээр магадгүй одоо зүгээр Мөнхсайхан гишүүд нарын өргөн барьсан байгаа хуулийг хэлэлцэх эсэхийг нь бид хэлэлцэж шийдвэрлээд, тэгээд дараагийн асуудалдаа, чуулгандаа орохгүй бол чуулганаар бас цаг хугацаатай асуудлуудыг хэлэлцэх учраас бид бас бүрэн ирцээрээ чуулганы нэгдсэн хуралдаандаа оролцох нь зүйтэй гэсэн ийм саналтай байна.

Б.Найдалаа: Ойлголоо. Саналыг ойлголоо. Тэгэхээр Баатархүү гишүүний асуулгатай холбоотой бас Баатархүү гишүүн санал, хүсэлт ирсэн байгаа. Тэгээд чуулган ч болж байгаа юм байна. Тэгэхээр дэгийн дагуу энэ 2 асуудлыг хэлэлцэх асуудлаас хасахын тулд тус бүрд нь санал хураах ёстой юм байна. Тийм болохоор түрүүн Саранчулуун гишүүний гаргасан саналын дагуу Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг орон сууцжуулах талаар Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдад хандсан асуултын хариуг хэлэлцэхийг хойшлуулъя гэсэн томьёоллоор санал хураана. Санал хураалтдаа бэлдье. Түрүүн миний хэлсэн томьёоллоор буюу 2 дугаар асуудлыг хойшлуулъя гэсэн томьёоллоор, хойшлуулахыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. Гишүүдийн 70,6 буюу 12 гишүүн дэмжсэнээр 2 дугаар асуудлыг Саранчулуун гишүүний тавьсан асуулгын асуултын хариуг хэлэлцэхийг хойшлуулж байна.

Дараагийн санал хураалт. Мөн ойролцоо асуудал. Улсын Их Хурлын гишүүн Баатархүүгээс Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагааны талаар эрүүл мэндийн сайдад хандсан асуулгын хариуг хэлэлцэхийг хойшлуулъя гэсэн томьёоллоор санал хураалт. Санал хураалтад оролцсон гишүүдийн 70,6 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Ингээд өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар 3 биш 1 асуудал хэлэлцэхээр боллоо. Хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүн байхгүй байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Улсын Их Хурлын гишүүн Мөнхсайхан, Мандхай, Энх-Амгалан нарын гишүүдээс 2025 оны 12 сарын 31-ний өдөр өргөн мэдүүлсэн Сургуулийн орчны эрүүл мэнд, аюулгүй байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг хэлэлцэж эхэлье.

Хуулийн төслийн үзэл баримтлалыг Улсын Их Хурлын гишүүн, хууль санаачлагч Мөнхсайхан гишүүн танилцуулна. Мөнхсайхан гишүүний микрофоныг нээе.

Т.Мөнхсайхан: Эрхэм хүндэт Байнгын хорооны дарга, гишүүд ээ, Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Өнөөдөр Монгол Улсын ирээдүй болсон хүүхэд, залуучуудын эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах асуудлын хүрээнд боловсруулсан Сургуулийн орчны эрүүл мэнд, аюулгүй байдлын тухай хуулийн төслийг танилцуулж байна.

Уг хуулийн төслийн бодлогын зорилттой уялдсан байдлыг авч үзэхэд Монгол Улс 2050 он гэхэд эрүүл насжилтаар бүс нутагтаа тэргүүлэх 10 улсын 1 болох зорилтыг дэвшүүлсэн. Энэ зорилгод хүрэхийн тулд бид иргэдийнхээ эрүүл насжилтыг дор хаяж 6 насаар нэмэгдүүлэх шаардлагатай. Энэ зорилгын суурь нь хүүхэд нас юм.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйл эрүүл, аюулгүй орчинд амьдрах, эрүүл мэндээ хамгаалуулах, сурч боловсрох эрхийг баталгаажуулсан. Гэвч бодит байдал дээр эдгээр эрхүүд сургуулийн орчинд бүрэн хангагдаж чадахгүй байна.

Мөн Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод эрүүл, зөв дадалтай иргэнийг багаас нь төлөвшүүлэх гэж тодорхой заасан. Иймд сургууль бол зөвхөн мэдлэг олгох газар бус, эрүүл амьдралын хэв маяг аюулгүй зан үйл төлөвшүүлэх үндсэн орчин байх ёстой. Өнөөгийн бодит нөхцөл байдлыг авч үзэхэд манай улс 1,3 сая хүүхэд, багачуудтай. Өөрөөр хэлбэл нийт хүн амын 36,2 хувийг 0-17 насныхан эзэлж байгаа юм. Үүнээс 2024-2025 оны хичээлийн жил улсын хэмжээнд өмчийн бүх хэлбэрийн ерөнхий боловсролын сургуульд 807,2, 2025-2026 оны хичээлийн жилд 820 орчим мянган хүүхэд ерөнхий боловсролын сургуульд суралцсаныг Үндэсний статистикийн хорооноос мэдээлсэн. Гэвч дараах ноцтой асуудлууд тодорхой шийдэлгүй байсаар байна.

1.Өвчлөлийн хувьд:

Шүдний өвчлөл хүүхдийн дунд тэргүүлэх шалтгаан хэвээр. Амьсгал хоол боловсруулах замын өвчлөл өндөр, сүрьеэгийн өвчлөл буурахгүй байна.

2.Осол гэмтлийн хувьд:

Монгол Улсын хэмжээнд сүүлийн 5 жилийн байдлаар 6-18 насны нийт 250 мянга орчим хүүхэд осол гэмтэлд өртсөн бөгөөд үүний 13,5 хувь нь сургуулийн орчинд осол гэмтэлд өртсөн байна. Осол гэмтэлд өртсөн хүүхдүүдийн 89,2 хувь нь санамсаргүй, 9,1 хувь нь санаатайгаар үйлдсэн гэмтэл, 1,7 хувь нь сэдэл тодорхойгүй осол байна. Осол гэмтлийн тэргүүлэх шалтгаан 1 дүгээрт уналт, 2 дугаарт амьгүй механик хүчинд өртөх, 3 дугаарт амьтай механик хүчинд өртөх, 4 дүгээрт хүчирхийлэл байна.

Мөн сургуулийн орчинд осол гэмтэлд өртсөн нийт тохиолдлын 5 жилийн байдлаар шалтгаан тус бүрээр нь харахад зам тээврийн осол, амиа хорлох, хүчирхийлэл гэх мэт шалтгаанууд өсөх хандлагатай байна.

Сурч боловсрох гэж очоод сургуулийн орчиндоо амь насаараа эрсэдсэн харамсалтай тохиолдлууд гарсаар байна.

2022 онд 6 настай хүүхэд санамсаргүй цохигдсон нийслэл хотод, 2023 онд 14 настай хүүхэд санамсаргүй цохигдсон, Ховд аймагт. 2024 онд 17 настай хүүхэд хүчирхийлэлд өртөж, найздаа зодуулсан, Завхан аймагт. 2025 онд 7 настай хүүхэд биеийн тамирын зааланд шүүгчийн төмөр сандалд дарагдсан, Өвөрхангай аймагт, Дараа жил аль аймагт, аль дүүрэгт вэ. Бид үүнийг засах ёстой. Бидний ирээдүй

болсон бяцхан үрсийнхээ эрүүл, аюулгүй орчинд сурч боловсрох боломжийг бүрдүүлэх нэн шаардлагатай байна.

3.Сургуулийн орчны эрсдэлийг авч үзэхэд:

НҮБ-ын хүүхдийн сангийн захиалгаар 2024 онд хийсэн хүүхдийн орчны эрүүл мэндийн түргэвчилсэн үнэлгээ, судалгааны үр дүнг харвал 79 хувь нь хурд сааруулагчгүй замтай ойр, 73 хувь нь аюулгүй спортын талбайгүй, 76 хувь нь ил задгай цахилгааны утасны эрсдэлтэй, 51 хувь нь авто замтай хэт ойр.

4.Дотоод орчны эрүүл ахуйн хүрээнд:

Сургууль, цэцэрлэгт засвар хийсний дараа будаг, бусад материалаас ялгардаг формальдегид стандарт хэмжээнээс 2-3 дахин их, бензол 3,5 дахин их, хар тугалга 2-5 дахин их, хром 2,3 дахин хэтэрсэн нь дотоод орчны судалгаагаар тогтоогдсон. Эдгээр бодис нь хорт хавдрын эрсдэл, дархлаа сулрах, хүүхдийн өсөлт хөгжилд сөргөөр нөлөөлөх архаг амьсгалын замын өвчин ихсэх эрсдэлийг дагуулдаг.

5.Агаарын бохирдол:

PM_{2,5} стандарт хэмжээнээс 8-9 дахин их байгаа нь сурагчид өдөр бүр эрүүл мэндэд хортой орчинд суралцаж байгааг харуулж байна.

6.Нийгмийн тулгамдсан асуудлын хувьд:

Сургуулийн орчинд зөвхөн дээрх асуудлаас гадна сурагчид хоорондын харилцаа хандлагын бодит асуудлууд болох үе тэнгийн дээрэлхэл тодорхой зохицуулагдаагүй байгаа нь өнөөдрийн нөхцөлд хүргэж байна. Сургуулийн орчны осол гэмтлийн тэргүүлэх шалтгааны 4 дүгээрт хүчирхийлэл, дээрэлхлээс үүдэлтэй гэмтэл бэртэл, 4 нас баралтын 1 нь үе тэнгийн дээрэлхлээс үүдэлтэй байгаа нь нийгмийн тулгамдсан асуудал болоод байна. Үе тэнгийн дээрэлхэл зөвхөн бие махбодын хүчирхийллээр хязгаарлагдахгүй, сэтгэл зүйн дарамт, доромжлол, гадуурхалт, мөн цахим орчин дахь дарамт зэрэг олон хэлбэрээр илэрдэг. Бид гэмтсэн, бэртсэн, нас баралтын тоогоор илэрхийлж чадах ч хүүхдийн сэтгэл зүйн дарамт, айдас түгшүүрийг тэр бүр илэрхийлж арга хэмжээ авч чадахгүй байгаа юм.

Нөгөө талаас дээрэлхэгч хүүхдүүд өөрсдөө зан үйлийн доголдол, хүчирхийллийг зөвтгөх хандлагатай болж, ирээдүйд нийгэмд сөрөг үйлтэй иргэн төлөвших эрсдэлийг дагуулдаг. Иймд сургуулийн орчинд үе тэнгийн дээрэлхлээс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, сэтгэл зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх тогтолцоог бүрдүүлэх нь хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хангах чухал арга хэмжээ юм.

Олон улсын туршлагаудыг харахад дэлхий дахинд сургуулийн орчны эрүүл мэндийг системтэй шийдсэн туршлага бий. Жишээлбэл ДЭМБ эрүүл мэндийг дэмжих сургууль, хөтөлбөр хэрэгжүүлдэг. Уг хөтөлбөрт нь сургуулийг бүхэлд нь хамарсан бодлого, орчин, үйлчилгээ, оролцоогоор дамжуулан хүүхэд болон хамт олны эрүүл мэнд, сайн сайхан байдлыг дэмжих цогц хөтөлбөр юм. НҮБ-ын Хүүхдийн сан хүүхдийн аюулгүй орчны стандартыг тодорхойлсон. Хүүхдийн аюулгүй орчин гэдэг нь хүүхдийн аливаа эрсдэлээс хамгаалж, эрүүл, аюулгүй хөгжих, суралцах, сэтгэл зүйн дэмжлэг авах нөхцөлийг бүрдүүлсэн орчин хэмээн тодорхойлсон.

Монгол Улс эдгээр сайн туршлагыг нутагшуулах шаардлагатай байна. Энэхүү хуулийн төсөл нь 4 бүлэг 27 зүйлтэй. Хуулийн төслийн бүлэг тус бүрээр харвал 1 дүгээрт сургуулийн орчны эрүүл мэнд, аюулгүй байдлын тухай хууль нь өмчийн хэлбэр харгалзахгүй бүх шатын сургуулийг орчинд суралцагчийн эрүүл мэндийг хамгаалж дэмжих, эрүүл, аюулгүй орчин бүрдүүлэх, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулж, хэрэгжилт, хяналт тавих харилцааг Монгол Улсын холбогдох хууль тогтоомж болон олон улсын гэрээнд нийцүүлэн ялгаварлан гадуурхахгүй, тэгш, хүмүүнлэг, нууцлалыг хангаж, суралцагчийн эрх ашгийн нэн тэргүүнд тавих зарчмаар зохицуулахад оршино.

2 дугаар бүлэг Эрүүл мэндийг дэмжих сургуулийн нэгдсэн бодлогын улсын хэмжээнд баталж сургууль бүр хэрэгжүүлэх, сурагчдын эрүүл мэндийг хамгаалах дунд хугацааны төлөвлөгөө, тогтмол үзлэг, эрт илрүүлэг, яаралтай тусламжийн бэлэн байдал, цахим бүртгэл, тайлагнал, нотолгоонд суурилсан төлөвлөлт, халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, сэтгэл зүйн дэмжлэг, эрүүл мэндийн боловсролыг цогцоор нь хэрэгжүүлэх замаар суралцагч, багш, ажилтны эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлж, хүүхдийн эрүүл мэндийн системтэй хамгаалах эрх зүйн үндсийг бүрдүүлэхэд чиглэнэ.

3 дугаар бүлэгт Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн 4 жил тутам үндэсний төлөвлөгөө баталж, орон нутаг жил бүр хэрэгжүүлж, сургууль өөрийн түвшний төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх шаталсан тогтолцоогоор сургуулийн орчны осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, гамшгийн үеийн анхан шатны чадвар олгох, сэтгэл зүйн болон нөхөн сэргээх дэмжлэг үзүүлэх, орчны аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартыг хангах, хариуцлагын тогтолцоог тодорхой болгох замаар суралцагчийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах, эрсдэлийг бууруулах эрүүл зан үйл, цогц орчныг бүрдүүлэхэд чиглэнэ.

4 дүгээр бүлэгт хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд заасан эрүүл, аюулгүй орчинд амьдрах, эрүүл мэндээ хамгаалуулах эрх, сурч боловсрох эрхийг баталгаажуулах ач холбогдолтой тул Монгол Улсын Үндсэн хуультай нийцнэ. Түүнчлэн хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгахгүй бөгөөд суралцагч хүүхдийн эрхийг хангах тогтолцоог бий болгох зорилготой тул Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай нийцнэ.

Уг хуулийн төслийг хэрэгжүүлэх үндсэн чиглэлийг дараах байдлаар тогтоолоо.

1. Урьдчилан сэргийлэх тогтолцоо.

Жил бүр эрүүл мэндийн үзлэг шинжилгээ хийх, эрсдэлийг эрт илрүүлэх эрүүл мэндийн цахим мэдээллийн санг бүрдүүлэх. Энэ нь өвчнийг хүндрэхээс өмнө илрүүлэх зорилготой.

2. Сургуулийн эрүүл мэндийн үйлчилгээ.

Стандарт хангасан эрүүл мэндийн өрөө, яаралтай тусламжийн бэлэн байдал, сэтгэл зүйн зөвлөгөө.

3. Аюулгүй орчин.

Осол гэмтлээс урьдчилан сэргийлэх төлөвлөгөө гадаад, дотоод орчны стандарт Гамшгийн үед хамгаалах сургалт.

4.Эрүүл мэндийн боловсрол.

Гар угаах, шүд угаах, хооллолт, хөдөлгөөн, сэтгэл зүй, бэлгийн боловсрол, донтолтоос сэргийлэх.

5.Хариуцлагын тогтолцоо тодорхой тусгалаа. Стандарт зөрчсөн тохиолдолд хариуцлага хохирол нөхөн төлөх механизм. Энэ нь бодлогын хэрэгжилтийг бодит болгоно.

Хуулийн төслийн онцлог заалтуудыг дурдахад Эрүүл мэндийг дэмжих сургууль нь сургуулийн эрүүл мэндийн бодлоготой байх бөгөөд сургуулийн эрүүл мэндийн бодлого нь энэ хуулийн 6.1-д заасан бодлогод нийцүүлэн сургуулийн эрүүл мэндийн баг боловсруулж батална. Сургууль нь 9 гишүүн бүхий эрүүл мэндийн багтай байх бөгөөд тус багт сургуулийн захирал, эрүүл мэндийн арга зүйч багш, сэтгэл зүйч, хоол зүйч, нийгмийн ажилтан тус бүр 1, суралцагч болон эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн төлөөлөл тус бүр 2 байхаар бүрдүүлнэ.

Суралцагчийн эрүүл мэндийг хамгаалах, дэмжих үйл ажиллагааны 4 жилийн төлөвлөгөөг эрүүл мэндийн болон боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран баталж, хэрэгжилтийг зохион байгуулна. Боловсролын асуудлыг эрхэлсэн Засгийн газрын гишүүнд 4 жил тутамд сургуулийн орчноос шалтгаалсан осол гэмтлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны үндсэн төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлж, олон нийтэд тайлагнахаар зохицуулсан бол энэхүү төлөвлөгөөнд нийцүүлэн сум, дүүргийн ИТХ болон тухайн шатны Засаг дарга сургуулийн орчноос шалтгаалсан осол гэмтлээс урьдчилан сэргийлэх орон нутгийн төлөвлөгөөг жил бүр баталж, хэрэгжүүлэх, тайлагнахаар, харин сургуулийн захирлын хувьд тухайн сургуулийн орчноос шалтгаалсан осол гэмтлээс урьдчилан сэргийлэх сургуулийн төлөвлөгөөг жил бүр боловсруулж, баталж, хэрэгжүүлэхээр зохицуулсан.

Энэ нь үндэсний түвшнээс орон нутаг сургууль хүртэлх шатлал бүхий төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналын нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, сургуулийн орчны аюулгүй байдлыг эрсдэлд суурилан үнэлэх, сайжруулах, хариу арга хэмжээ авах үйл ажиллагааг тасралтгүй үргэлжлүүлэх нөхцөлийг хангах эрх зүйн үндэс болно.

Эрхэм гишүүд ээ,

Хүүхдийн эрүүл мэнд бол зөвхөн эрүүл мэндийн салбарын асуудал биш. Энэ бол улсын хөгжлийн суурь асуудал юм. Эрүүл боловсролтой иргэн эх орны хөгжлийн үндэс юм. Сургууль бол хүүхдийн амьдралынхаа хамгийн их цагаа өнгөрөөдөг орчин. Тиймээс бид энэ орчныг эрүүл, аюулгүй хамгаалалттай болгох үүрэгтэй. Иймд сургуулийн орчны эрүүл мэнд аюулгүй байдлын тухай хуулийн төслийг дэмжин хэлэлцүүлж өгөхийг хүсье.

Анхаарал хандуулсан та бүхэнд баярлалаа.

Б.Найдалаа: Танилцуулга хийсэн Мөнхсайхан гишүүнд баярлалаа. Байнгын хорооны хуралдаанд ирсэн ажлын хэсгийг танилцуулъя. М.Цогзолмаа Боловсролын яамны Ерөнхий боловсролын бодлого зохицуулалтын газрын дарга, Д.Дуламсүрэн Боловсролын яамны Ерөнхий боловсролын бодлого зохицуулалтын газрын шинжээч, Д.Соёлмаа Боловсролын яамны Ерөнхий боловсролын бодлого зохицуулалтын газрын шинжээч, Э.Чойсүрэн Боловсролын яамны Бодлого төлөвлөлтийн газрын шинжээч, С.Пүрэвсайхан Боловсролын яамны Бодлого

төлөвлөлтийн газрын шинжээч, Л.Баттөр Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирал, Ч.Ариунболор Нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийн газрын мэргэжилтэн, Д.Нарансүх Анагаах ухааны доктор, профессор, О.Чимэдсүрэн Анагаах ухааны доктор, профессор, М.Намхайрэнчин Удирдахуйн ухааны доктор, Улсын Их Хурлын гишүүний ажлын алба, Б.Буянтогтох Улсын Их Хурлын гишүүний ажлын алба, Н.Тунгалагсайхан Улсын Их Хурлын гишүүний ажлын алба, С.Энхцолмон судлаач.

Одоо хуулийн төсөл санаачлагчийн илтгэлтэй холбогдуулаад асуулт асуух гишүүд байвал нэрсээ өгье. Саранчулуун гишүүнээр тасалъя. Ирцээрээ эрэмбэлэгдээд Зулпхар гишүүнээс эхлэх юм байна. Зулпхар гишүүн.

С.Зулпхар: Дарга, гишүүд, хууль санаачлагчдын энэ өдрийн амар амгаланг айлтган мэндчилье. Энэ яах вэ их чухал хууль гэдгийг бол бид бүгдээрээ мэдэж байгаа. Тэгээд манай нийгмийн гол үндсэн бүлэг болсон цаашид улс орны хөгжлийн ирээдүй болсон сурагчдынхаа, хүүхдүүдийн хамгаалал хөгжлийн асуудалд анхаарна гэдэг бол Засгийн газрын зорилго мөнөөсөө мөн. Төрийн зорилго угаасаа хуулиар бол мөнөөсөө мөн гэж байгаа юм.

Гэхдээ бас энэ хүрээнд бол тодорхой хуулиуд бол бас байгаа. Ажлын хэсгийнхэн бол энийг сайн судалсан гэдэгт бол эргэлзэхгүй байна. Хүүхэд хөгжлийн тухай хууль байгаа. Хүүхэд хамгааллын тухай хууль байгаа. Бид нэгдэн орсон конвенцынхоо дагуу эдгээр хуулиудыг батлаад, хэрэгжүүлээд, холбогдох бас зохион байгуулалтууд нь байж байгаа юм. Яам нь байна. Агентлаг нь байна. Энийг хэрэгжүүлэх гээд бас хичээж байгаа. Салбар дундын шинжтэй асуудал учраас Эрүүл мэндийн яам, Боловсролын яам, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам гэсэн ийм гуравласан байдлаар энэ асуудалд бас оролцдог.

Монгол Улсын Ерөнхий сайд өөрөө Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн бас тэргүүн. Хүүхдийн асуудал 1 дүгээр чухал асуудал учраас гээд ингээд үзэх юм бол бидэнд тодорхой жишээ нь эрх зүйн орчин байна. Институцийн бас зохион байгуулалт бол байна. Ямар нэгэн байдлаар бас чадавх бол бэхжиж байгаа. Гэхдээ бол тэр орон зайд бол бас зайлшгүй шийдэх ёстой асуудал байгаа учраас энэ хууль гарч ирж байна гэж ойлгож байгаа юм. Энэ хуулийг бол би зарчмын миний хувьд бол дэмжиж байгаа. Цаашдаа энийг бол бид гэхдээ нарийн хэлэлцээд л явах ёстой гэж үзэж байгаа юм.

Гэхдээ асуулт байна. 1 дүгээр асуулт ажлын хэсгийнхнээс энэ хүүхэд хөгжил, хүүхэд хамгааллын хууль, тэрийг дагалдаж гарсан стандартууд байгаа юм. Сургуулийн орчинд. Тухайлбал тэр нөгөө үе тэнгийнхний дээрэлхэлтэй холбоотой энэ чинь тодорхой тогтсон өөрийн гэсэн стандарттай шүү дээ. Хариу арга хэмжээ авахтай холбоотой хамтарсан баг яаж ажиллах вэ гээд. Тэгэхээр энэ зүйлүүдийг та бүхэн хэр судлаад, тэгээд энэ хуульд давхцуулаагүй, эсвэл уялдуулсан байдлаар тусгах чиглэлээр яаж ажилласан бэ гэж байгаа юм. Энэ дээр ялангуяа би энэ асуудлыг сайн мэддэг судлаачид энд хариулаач ээ гэж давхар хүсэж байна. Энийг бид их тодорхой ярих ёстой. Яагаад гэвэл дараа нь ингээд баахан хууль байгаад байгаа юм шиг мөртөө тэгээд хэн нь хариуцах нь мэдэгдэхээ байчихдаг тохиолдлууд бас гарсан. Өнгөрсөн хугацаанд бол энэ ажил хариуцаж байсан хүмүүс энд сууж байгаа учраас тэрийг зориуд хэлж байгаа юм.

2 дахь зүйлийг би энэ Нарансүх даргаас бас асууя. Энэ хөдөлмөр аюулгүй байдлын чиглэлээр чухал саналууд орж ирж байгаа. Хөдөлмөрийн аюулгүй байдал,

эрүүл ахуйн тухай хуулиар бид зохицуулж болж байгаа зүйл байгаа юу. Сургуулийн орчинд. Энэ чинь цэвэр аюулгүй байдлыг хангахтай холбоотой асуудал шүү дээ. Сургууль өөрөө хангадаг, эцэг эх хангадаг, суралцагч өөрөө хангадаг гээд ингээд асуудал байгаа шүү дээ. Тэгэхээр үүнтэй холбоотой зүйлийг энэ хуулийн төслийн хүрээнд танай талаас, жишээ нь танай мэргэжлийн байгууллагын хувьд ямар санал хэлсэн бэ гэдэг ийм асуулт байна.

3 дахь зүйл хууль хэрэгжихэд бол яах вэ бид өнгөрсөн хугацаанд хуулиуд гаргаад, тэгээд 1 удаа бид чинь 1 хууль гаргаад, тэгээд тэр хуультай холбоотой хүүхэд хамгааллын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулчхаад төсөв нь байхгүйгээс болоод хууль нь хэрэгжихэд 1, 2 жил болж байсан юм. Нийгмийн ажлуудын л асуудал юм л даа. Тэгэхээр энд дандаа цаана ... /минут дуусав/

Б.Найдалаа: 1 минут Зулпхар гишүүн.

С.Зулпхар: Дандаа зардал байхгүй бол нөгөө хууль маань ингээд зогсчихдог эсвэл тодорхой зүйлүүд нь хэрэгждэггүй. Тэр институц нь байхгүй учраас гээд. Тэгэхээр ингээд нөгөө сургуулийн хүүхдүүдийг эрүүл мэндийн үзлэгт хамруулах тухай маш тодорхой ийм бүлэг орж ирлээ. Би энийг бол зөв гэж бодож байна.

Гэхдээ өнөөдөр байгаа практик яаж явж байгаа юм. Энэ дээр чинь эцэг эхчүүд хариуцдаг. Голцуу бид бол сургууль эхлэхийн өмнө энэ дээр бол орон нутгийн засаг захиргаа хариуцна. Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагатай хамтраад жишээ нь хариуцна гэхчхэн байгаа. Тэгэхээр үүний цаана гарах зардлын тооцоо хийгдсэн үү. Энэ зохион байгуулалттай холбоотой зүйлийг та бүхэн бас нарийн судалж үзсэн үү. Ялангуяа эрүүл мэндийн асуудал хариуцаж байсан Мөнхсайхан гишүүн бол өөрөө сайд нь байсан учраас энэ практикийг сайн мэдэж байгаа байх. Энэ хийх нь чухал. Гэхдээ хийхдээ бол зүгээр ингээд ёс төдий хийх бол биш. Үнэхээрийн жишээ нь зөв зохион байгуулалтыг хийх гэж байгаа юм байна. Гол нь зохион байгуулалт, зардал мөнгөний асуудал энэ дээр бас тооцогдсон уу гэдэг ийм асуулт байна. Баярлалаа.

Б.Найдалаа: Хариултыг Мөнхсайхан гишүүнээс эхэлнэ.

Т.Мөнхсайхан: Баярлалаа. Бид нар энэ хуулийг боловсруулахын тулд сургуулийн орчны эрүүл мэнд, аюулгүй байдалтай холбоотой нэлээн хэдэн хуулиуд байгаа. Эд нарыг бүгдийг нь судалж үзээд, ямар нэгэн давхардал байхгүй. Гэхдээ энэ зүйл, заалт байхгүй бол зайлшгүй шаардлагатай байгаа энэ зүйлүүдийг энэ хуульдаа тусгасан. 1 дүгээрт.

2 дугаарт бид нарт энэ сургуулийн орчны талаар маш олон стандартууд байгаа. Гэхдээ өнөөдрийг хүртэл энэ стандартууд хангагдахгүй, мөрдөгдөхгүй байсаар байгаад сургуулийн орчны аюулгүй байдал маш хангалтгүй байгаад байгаа юм. Тэгэхээр энийг бид нар хэрхэн яаж цаашид нь хангаж явах вэ гэдэг энэ процессын чанартай. Хангаагүй тохиолдолд хэн, яаж хариуцлага хүлээх юм бэ гэдэг энэ системийг бий болгох зорилготой л энэ хуулийг санаачилж хийж байгаа юм. Тэгээд энэ дээр манай ажлын хэсэг маань бас илүү дэлгэрэнгүй хариулах байх. Энэ тогтмол үзлэг шинжилгээ бид нар эрүүл ирээдүйг бий болгоно гээд байгаа шүү дээ. Тэрийг бид нар хүүхэд наснаас нь авхуулж энэ өвчлөлийг илрүүлж оношилж эмчлэхгүй бол өнөөдөр жил ирэх тусам нэмэгдэж байгаа энэ өвчлөл бол буурахааргүй байгаа юм. Тэгээд өнгөрсөн хугацаанд энэ сургуульд суурилсан эрт илрүүлэг, оношилгоо үзлэгүүд бол хийгдэж ирсэн. Энэ хийгдэх төсөв мөнгө маань

Эрүүл мэндийн даатгалын санд ер нь харьяалагдаж, хамрагдаж явдаг. Дээрээс нь энэ үзлэг оношилгоонд ихэвчлэн анхан шатны эрүүл мэндийн байгууллагууд оролцдог. Тэд нарын хийх ёстой ажлын нэг хэсэг. Тийм учраас энэ дээр тусгайлан онцгойлсон тийм төсөв мөнгө шаардахгүй. Одоо байгаагаас илүү төсөв мөнгө шаардахгүй. Гагцхүү зөвхөн энэ сургуульд суурилсан эрт илрүүлгийг оновчтой зөв, тасалдуулахгүй жил болгон хийхээр хуульчилж өгөхгүй бол Засгийн газрын гишүүн, Эрүүл мэндийн сайд, Боловсролын сайд хэн байхаас шалтгаалаад энэ урьдчилан сэргийлэх үзлэг хийгддэг, хийгддэггүй, оновчтой, оновчгүй гэх байдлаар яваад байгаа учраас энийг бид нар хуульчилж өгснөөрөө жил болгон тогтмол энэ үзлэг оношилгоо маань хийгддэг энэ тогтолцоо бүрдэх юм. Энэ тогтолцоо бол бусад улсуудад эрүүл мэндийн салбар хөгжсөн, илүү их өндөр насжилт өндөртэй энэ улсуудад бүгдэд нь бий болсон байдаг тогтолцоо. Сургуулийн орчны эрүүл мэнд, аюулгүй байдлын хууль ч гэсэн олон улсын практикт ихэнх улсуудад байдаг. Бид нарын мэдэх Япон, Солонгос. Солонгост бол 1950, 1960 онуудаас эхлээд энэ сургуулийн орчны эрүүл мэнд, аюулгүй байдлын тухай хуультай болсон. Энэ нь ч маш их өндөр үр дүнгээ өгсөн ийм судалгаанууд байгаа. Тэгээд манай ажлын хэсгээс нэмж хариулах зүйл байвал тодруулаад хариулчих.

Б.Найдалаа: Дараагийн асуулт. Хариулахаар бол индэр лүү гарч хариулах юм байна шүү. Зулпхар дарга хэнээс хар асуусан билээ. Тийшээ гараарай. Индрийн микрофоныг нээе.

Д.Нарансүх: Ажлын хэсгийн гишүүн Нарансүх. Миний бие ажлын хэсэгт энэ хууль гаргахын өмнөх судалгаа, НҮБ-ын хүүхдийн сангийн захиалгаар хийсэн хүүхдийн орчны эрүүл мэндийн түргэвчилсэн үнэлгээ, дараагийн судалгаа нь эрүүл сургууль цогц үнэлгээний судалгаа гэсэн ийм 2 судалгаан дээр ажилласан. Энэ хүрээндээ сая Зулпхар гишүүний асуусан тэр сургуулийн орчинд хүүхэд аюулгүй суралцах, сургуульд суралцаж байх орчиндоо бас осол гэмтэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, мөн сургуулийн гадаад, дотоод орчны аюулгүй байдлын талаас бас холбогдох ийм үндэслэл судалгааг бол яг хуулийн төсөл боловсруулж байгаа ажлын хэсэгт судалгааны тайлан хэлбэрээр гаргаж өгсөн. ХАБЭМТ-ийн хувьд бол сургуулийн орчинд хүүхэд маань сургуульд суралцах нь өөрөө бас нэг хэлбэрээр зарим тохиолдолд ахлах ангийн хүүхдүүдэд бас ажил, хөдөлмөрийн ийм харилцаа орж байгаатай төстэй ажлын байрны эрсдэлд өртөх, үйлдвэрлэлийн орчны эрсдэлд өртөх энэ эрсдэлийг бууруулахад чиглэсэн үнэлгээг сургуулийн орчны үнэлгээ хийх үедээ хамт оруулах ийм зөвлөмжийг бас хуулийн ажлын хэсэгт бид албан ёсоор судалгааны тайлан дээр үндэслээд гаргаж өгсөн. Тэгээд энэ асуудлууд маань хуулийн төсөлд ороод, үнэлгээ болоод явж байгаа. Мөн ажилчдын эрүүл мэндийг дэмжих, сайн сайхан байдлыг дэмжих гэсэн бүлгүүд бас үнэлгээнд орохоор тусгагдсан байгаа.

Б.Найдалаа: Болсон уу. Тэгвэл дараагийн гишүүн Ганмаа гишүүн асуулт асууна.

Д.Ганмаа: Сайн байцгаана уу. Энэ сургуулийн орчны эрүүл мэнд, аюулгүй байдлын тухай хуулийн төсөл дээр бол яах вэ, уншаад үзэхээр зэрэг тэнд чинь нэг ч буруу үг, үсэг, өгүүлбэр байхгүй. Хүн болгон харахаар зэрэг дэмжихээс аргагүй зайлшгүй шаардлагатай юм байна. Хүүхдээ эрүүл байлгая, урьдчилан сэргийлье, архаг өвчнөөс багасгая гэхээр чинь хэн ч үгүй гэж хэлж чаддаггүй шүү дээ. Ер нь за тэлье тэлье, тэгэлгүй яах вэ, дэмжихгүй бол ерөнхийдөө маш эвгүй байдалд орчихдог. Нөгөө хавдрын эмнэлэг бариад бүх нас баралтыг бууруулна гэж шууд хэлээд, гараа өргөөд бүгд дэмждэгтэй яг адилхан зарчим ажиллаад байгаа байхгүй

юу. Гэхдээ цөмөөрөө хуулиа ер нь жоохон бодлоготой, тооцоо судалгаатай, шинжлэх ухаанд суурилсан, үнэн зөв, бодит дата энэ тэрээ нэг сайталдаг байвал их зүгээр санагдаад байгаа юм.

Яах вэ, цөөн хэдэн юм энд асууя л даа. Бид нар энд сургуулийн орчны эрүүл мэнд, аюулгүй байдлыг харахаар зэрэг 1 дүгээрт энэ уг хуулийн төсөлд сая Зулпхар гишүүн ч бас хэлж байна. Бие даасан шинэ эрх зүйн зохицуулалт нь бараг агуулагдаагүй юм шиг санагдаад байгаа юм. Нийт хуулийн 27 зүйл, 109 орчим хэсгийг нэг бүрчлэн уншаад үзэхээр 80 гаруй хувь нь эдгээрээс хүчин төгөлдөр одоо мөрдөгдөж байгаа Хүүхдийн эрхийн хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Эрүүл мэндийн тухай, Эрүүл ахуй болон нийгмийн эрүүл мэндийн тухай гээд тогтоомж заалтуудтай ер нь агуулгын хувьд давтагдаад байгаа байхгүй юу. Яг давхцаад байгаа юм. Тэгэхээр энэ өмнө нь зохицуулчихсан харилцааг давхардуулан тусгагдаж байгаа юм шиг ийм байдалтай харагдаад байгаа. Ер нь ингээд сая бас Мөнхсайхан гишүүн энд хариулж байна л даа. Энэ хууль бие даасан хууль байдлаар явуулахгүй бол энэ хэрэгжихгүй байгаад байх магадлал байна гээд. Энэ шинэ бие даасан хууль болоод явчихлаа гэж бодоход бид нар хуулийг хэрэгжүүлэхийн тулд 2 л юм байгаа шүү дээ. Эсвэл хяналт шалгалтаа чангална. Эсвэл мөнгө төгрөг, санхүүгийн хөшүүргээр л явна. Өөр ямар ч арга байхгүй. Гэтэл эндээс ингээд харахаар чинь зэрэг мөнгө төгрөгийн хөшүүргээ тавьчихъя. Хөтөлбөр тус бүр хийх ажил болгон дээр ингээд явахаар зэрэг тэр мөнгө төгрөг, санхүүжилт нь бас ерөөсөө байхгүй.

Эрүүл мэндийн даатгалын сан дээр энэ мөнгө тусгагдаад явна. Эрүүл мэндийн даатгалын сан чинь одоо архагаа ч авахаа больчихоод байна шүү дээ. Архаг өвчлөлөөсөө болоод хүмүүсээ зогсоогоод, тэрэнтэй холбоотой нас баралт өндөр байна. Хүндрэлүүд их байна. Хүмүүс шууд ухаангүй цус харвасан, амьсгалын зүрх, цусны дутагдалтай. Бүр үнэхээр том асуудал болчихоод байгаа байхгүй юу даа. Тийм байхад бид нар энийг ингээд тусад нь болгож гаргаад, мөнгө төгрөг зарцуулаад яваад байхаар нөгөө гол хэрэгтээ амь нас аврах, хүндрэлийг бууруулах, нас баралтыг багасгах энэ асуудлаас санхүүжилт яг багасаад байна. Тэгээд энэ санхүүжилтийг нь юуг нь харж байна. sightation хаанаас ямар санхүүжилт хэмнэх юм бэ гэдгийг. Минутаа авчихъя.

Б.Найдалаа: 1 минут нэмж өгье.

Д.Ганмаа: Энэ дээр харахаар нөгөө зарцуулж байгаа 1 доллар ... энэ хуулийн зарцуулж байгаа ДЭМБ-аас дурдсан, нийгмийн эрүүл мэндэд зарцуулсан 1ам.доллар нь 40 ам.доллар-ын зардлыг хэмнэнэ гэсэн үзүүлэлт байгаад байгаа юм. Тэгэхдээ энэ чинь их ерөнхий түвшний sightation шүү дээ. Олон улсын түвшинд үнэлгээ хийхэд 1 улсын тэр дундаа тодорхой хуулийн төслийн хэрэгжилтэд ерөөсөө шууд хамааруулж ойлгож огт болохгүй байхгүй юу. Харин ихэвчлэн prolonged буюу удаан хугацаанд хүн амын түвшний урьдчилан сэргийлэх бодлогын үр нөлөөг илэрхийлдэг ийм тооцоо судалгааг энд оруулж ирээд8 хязгаарлагдмал хуулийн төслийн үр дүнг шууд илэрхийлж бас болохгүй байх гэж бодож байна. Яах вэ ер нь тийм. Тэгэнгүүт одоо ингээд шинээр зарцуулж байгаа 16,2 тэрбум төгрөг нь шинээр бий болгох хэмнэлттэй гэдэг бас тийм conclusion тэр дор нь ингэж үр дүнг нь ингэж гаргаж болохгүй байна.

Ингээд зардал, үр өгөөжийн харьцааг ингээд бодитой үнэлэх, ямар өвчлөлөө бууруулах юм, ямар хугацаанд юм .../минут дуусав/

Б.Найдалаа: Хариултаа авчхаад, дараа нь тодруулах уу. Мөнхсайхан гишүүн хариулъя.

Т.Мөнхсайхан: Баярлалаа. Тэгээд бусад хуулиудтай ямар зүйл заалт юм. Яг тодорхой яривал. Тэд дүгээр зүйлийн тэд дүгээр заалт нь тэр хуультай давхцаад байна. Тэр хуулийн ийм зүйл, заалттай давхцаад байна гэдэг зүйлийг хэлбэл бид нар энэ дээр бас эргээд хэдүүлээ ажлын хэсэг дээрээ яриад, энийг өөрчлөх, нэмж, хасах боломжууд бүгдээрээ байж байгаа. Бид нар бүх хуулиудыг түрүүн хэлсэн. Судалсан. Ямар нэгэн тийм хийдэл, давхардал байхгүйгээр бид нар энэ хуулиудыг хийсэн юм байгаа юм.

Энэ санхүү мөнгөний хувьд Эрүүл мэндийн даатгалын сан дээр нэмж ачаалал өгөх гэж байгаа зүйл бол огтоосоо байхгүй шүү. Өнөөдрийг хүртэл Эрүүл мэндийн даатгалын сангаас урьдчилан сэргийлэх үзлэг, эрт илрүүлэг угаасаа санхүүжилт нь хийгддэг. Бид нар энэ урьдчилан сэргийлэх эрт илрүүлгээ ирээдүй болсон хүүхэд, залуучууд руугаа илүү их чиглүүлэх нь бодит үр өгөөжийг авчирна. Эрүүл монгол хүн бий болгох энэ тогтолцооны эхлэл болно гэдгийг олон талын судалгаагаар тогтоочихсон. Бусад улс орнуудын жишгээс харчихсан юм. Тэгэхээр энэ дээр ямар нэгэн байдлаар эргээд даатгалын санд ерөөсөө ачаалал өгөх гэж байгаа зүйл огтоосоо байхгүй. Өнөөдрийн хийж хэрэгжүүлж байгаа урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн ирээдүй болсон хүүхэд, залуучууд руугаа л чиглүүлчихье гэдэг.

Тэр судалгаанууд бол ерөнхийдөө 1 иймэрхүү судалгаа тооцоонууд байдаг л гэдэг зүйлийг зүгээр жишээ болгож, ингэж хамруулж, ингэж тайлбарлаж ярьж байгаа зүйл байх. Түүнээс биш яг энэ хууль дээр тодорхойлоод хийчихсэн тийм судалгаа бол биш. Энийг бол бас анхаарах нь зөв байх. Манайхнаас нэмж хариулах хүн байвал.

Б.Найдалаа: Ганмаа гишүүн тодруулах уу. 1 минут байгаа.

Д.Ганмаа: Яах вэ, зөв зүйтэй. Бид нар хууль тогтоомж, зүйл, хэсэг, заалт тус бүрээр нь хүснэгтээр гаргачихсан байгаа. Одоо ярья гэвэл 1 минутад багтах ч үгүй байх. Ярилаа ч гэсэн хариулахад бас амаргүй л байх. Тэгэхээр энэ ажлын хэсэгт юм уу эсвэл энэ дээр оруулчихъя л гэж бодож байна. Тэгээд тэр дээр хариултаа өгнө биз.

Ер нь бол зарчмын хувьд саяын ярьж байгаа дээр жишээлбэл бид нар яах юм. Сургуулийн орчны хууль, Уурхайн хууль, Үйлдвэрийн хууль, одоо юу гэдэг юм ингээд орчин орчноор нь хуваагаад явчих юм уу. Энэ чинь нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, нэр нь бас буруу энэ хуулийн. Яг үнэндээ би маш шүүмжлэлтэй ханддаг. Тэгэхдээ энэ Нийтийн эрүүл мэндийн тухай хууль дээр чинь энэ орчноо цогцоор нь, бодлогоор нь хийдэлгүй, давхардалгүй яваад, тус тусад нь зохицуулах ёстой юман дээр яагаад бид нар ингээд бага багаар нь авч гаргаад, энэ дээр нь хууль болгож гаргаад, тэгээд тус тусад нь хөтөлбөр болгоод яваад байдаг юм бэ. Яах вэ, Эрүүл мэндийн даатгалын сангаасаа .../минут дуусав/

Б.Найдалаа: Мөнхсайхан гишүүн хариулна. Тусдаа ийм хууль байх шаардлагатай юм уу л гэсэн санаа байх шиг байна шүү дээ зөв үү.

Т.Мөнхсайхан: Тэгэхээр энэ хуулийн хэрэгцээ шаардлагын судалгаанууд хийгдчихсэн байгаа шүү дээ. Энэ материалууд та бүхэнд бүгдэд нь очсон. Зайлшгүй бид нарт шаардлага байна гэдэг ийм судалгааны хариу, мэдээллүүд гарсан. Бидний

хувьд, миний хувьд ч гэсэн энэ бол зайлшгүй шаардлагатай байна. Яагаад гэвэл өнгөрсөн хугацаанд хэрэгжиж ирсэн бид нарын баримталж байгаа энэ хууль тогтоомжуудын үр дүнд өнөөдөр манай улсад байгаа бүх сургуулиудын 60-аас дээш хувь нь аюулгүй байдлыг хангаж чадахгүй байна. Энэ тэгвэл хэвийн үзэгдэл юм уу. Хүүхэд сурч боловсрох орчиндоо очоод амь нас эрсдэж байгаа энэ тохиолдлууд өнөөдөр гарсаар байна. Энийг хэвийн үзэгдэл мэт хүлээж авдаг болчихсон байна. Энийг өөрчлөх нь бид нарын буруу юу гэдэг энэ асуудал. Ирээдүй болсон хүүхэд залуучууддаа мөнгөө зарцуулахгүй өөр гол юунд мөнгө зарцуулах гээд байгааг би бас ойлгохгүй байна.

Б.Найдалаа: Тодруулж дууссан. Та асуултаа надад ч юм уу өгчих. Тэгвэл үг хэлэх дээрээ хэлчих юм байна. Рэгдэл гишүүн асуулт асууна.

Д.Рэгдэл: Баярлалаа. Тэгэхээр анхдагч хуулийн төсөл орж ирж байгаа юм байна. Асуудал нэлээн нарийн яригдах байх. Ер нь бол сургуулийн орчны эрүүл мэнд, аюулгүй байдал гээд бодохоор хууль байж байх нь зөв гэж зарчмын хувьд бол дэмжиж байгаа юм.

Тэгээд хэд хэдэн асуулт байна. Маш товчхон, тодорхой хариулт өгөөрэй гэж хүсье. Хуулийн нэр 2 өөр нэр яваад байна. Өргөн барихдаа 1 нэртэй, Засгийн газрын хурлаар оруулахдаа өөр нэрээр оруулж хэлэлцээд, хамгийн сүүлд нэмэлт дагалдах хуулиудаараа сургуулийн орчинд суралцагчийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах тухай хууль гэж биччихсэн байгаа юм. Энэ тэгэхээр яагаад энэ 2 нэр яваад байна вэ гэсэн нэг асуулт.

Дараа нь энэ сургуулийн орчны эрүүл мэнд, аюулгүй байдал гэдгийн 1 чухал хэсэг бол тэр сургуулийн суралцагчдын хүнсний эрүүл ахуй, аюулгүй байдлын асуудал байгаа юм. Тэгээд энэ дээр 24 дүгээр зүйл гээд цаана нь өөр хууль байгаа байх. Тэгэхдээ энэ 24 дүгээр зүйл гээд ганцхан зүйл оруулаад, энд ерөөсөө шалгалт хийх тухай л юм биччихсэн байгаа юм. Тэгэхээр энэ хүнсний эрүүл мэнд, аюулгүй байдлын асуудлыг нэлээн дэлгэрэнгүй оруулах боломж байдаггүй юм уу. Эсвэл холбогдох хууль байдаг юм бол тэрийг нь дагалдах хууль дээр нэмэлт маягаар тодруулж өгсөн юм юу байна вэ гэдэг нэг ийм асуулт байна.

Сургуулийн барилга бол манай Монголын толгойны өвчин. Улаанбаатарт сургуулийн барилга барих газар олдохгүй, мөнгө нь олддог л ийм зовлонтой болчихсон. Тэгээд энэ нэмэлт шаардлагуудыг чинь хараад байхаар сургуулийн барилга барихад ер нь бараг боломжгүй болчихоод байгаа юм. Явж явж нэг газраа олно. Тоосжилт өндөртэй бүсэд барьж болохгүй гэж байгаа юм. Энэ 20 дугаар зүйл. Тэгэхээр гэр хороололд энэ чинь үндсэндээ барьж болохоо байчхаж байгаа юм. Тэр нүүрс түлж байгаа гэр хороололд бол тоос, нарийн тоосжилт бол угаасаа өндөр. Тэгэхдээ энэ нарийн тоосжилт гэдгээ бас тодруулж өгвөл зүгээр. Тэр 2,5 РМ нь ч юм уу, юу л байх юм. Зүгээр ерөнхийдөө нарийн гэхсэн.

2 дугаарт энэ тогтмол дуу чимээний бохирдолтой бүсэд барьж болохгүй гэж байгаа юм. Ингэхээр чинь Улаанбаатарт бас барилга сургууль барих газар олоход их хэцүү. Харин тэр дуу чимээг багасгах, тэр тоосжилтыг багасгах, энэ арга хэмжээгээ л авах асуудал нь чухал юм уу гэж санагдаад. Энэ 2 шаардлагаас чинь болоод хууль батлагдмагц барилга барьж чадахаа больчих вий. Энэ дээр та нар бас тайлбар өгөөч ээ гэсэн юм байна.

3 дугаарт энэ хуулийн заалтуудыг хараад байхаар зарим юм дээр энэ сургалт, хяналт шалгалт, төлөвлөлттэй холбоотой юман дээр зарим юмыг нь сургууль хариуцна гэж байгаа юм. Заримдаа сургуулиас хариуцна гэж байгаа юм. Заримдаа захирал хариуцна гэж байгаа юм. Энэ 3-ын хооронд ямар ялгаа байгаа юм бэ. 3 өөр субъект болоод байна шүү дээ энэ чинь бараг. Яах вэ 2 ч гэж үзэж болох юм уу.../минут дуусав/

Б.Найдалаа: 1 минут Рэгдэл гишүүнд.

Д.Рэгдэл: Хийдэл, давхардал, тэгээд хүний эрхийн зөрчил, санхүүжилтийн талаар хийсэн судалгаа энэ тэр байвал энэ Их Хурал дээр бий болгочихсон тэр хиймэл оюуны платформоор оруулаад, нэг шалгаад оруулаад ирвэл бас зүгээр. Ер нь хуулийг зарчмын хувьд бол дэмжиж байна.

Б.Найдалаа: Мөнхсайхан гишүүн хариулна.

Т.Мөнхсайхан: Энэ 2 нэр томъёоны асуудал Засгийн хурлаар бол бараг жилийн өмнө шахуу хэлэлцэгдэж орсон юм. Тэр дээрээ өөр нэртэйгээр орчихсон юм. Тэгээд энэ нөгөө бусад улсын хууль тогтоомжтой энэ хамрах хүрээгээ харж байгаад одоо яг эцсийн нэршил нь бол Сургуулийн орчны эрүүл мэнд, аюулгүй байдлын тухай хууль юм байгаа юм. Тэр нэршлээр нь та ойлгож болно.

Энэ сургуулийн хүнсний тал дээр бие даасан хууль байгаа. Сургуулийн нөгөө хоол үйлдвэрлэл, технологийн тухай хууль гээд. Тэр дээрээ бол энэ асуудал дэлгэрэнгүй хүнсний талын зүйлүүд нь илүү их дэлгэрэнгүй орчихсон байгаа. Бид нар сургуулийн орчин гэхээр сургуулийн эргэн тойрны 150 метр радиусыг авч үзээд байгаа юм. Тэгээд өнөөдөр энэ шинээр баригдаад ашиглалтад орж байгаа сургуулиудыг аваад үзэхээр 150 метрийн радиус дотор хүүхдийн аюулгүй байдал хангагдаж байгаа зүйл маш ховорхон байгаад байна. Тэгэхээр бид нар хүүхдүүдээ сурч боловсрох орчныг нь бүрдүүлээд, 1 сургуультай л болгож байвал тэр орчин нөхцөл нь яах вэ гэдэг энэ үзлээсээ салахгүй л бол өнөөдөр боловсрол, мэдлэг эзэмших гэж очоод эрүүл мэндээрээ, амь насаараа хохирчхоод байгаа ийм тохиолдлууд их гараад байгаа учраас бид нар энэ орчны шаардлагаа хатуу тавих нь зөв гэж зарчмын хувьд үзэж байгаа. Гэхдээ энэ дээр бид нар энэ орчныг нь бүрдүүлчих юм бол саяын тэр аюулгүй байдал, тоосжилт, дуу чимээ тусгаарлах энэ арга хэмжээнүүдээ авч байж энэ сургуулиа барья. Шинээр барьж байгуулж байгаа бид нар хуучнаа засаж залруулахад хугацаа орно, төсөв мөнгө их орно. Ядаж шинээр орж байгаа барилгууд дээрээ энэ стандарттай энэ хуулиа бид нар мөрдүүлээд явах юм бол 10, 20 жилийн дараа манай улсад сурч боловсорч байгаа хүүхэд, багачууд маань аюулгүй, эрүүл орчинд сурч боловсроод, эрдэм мэдлэгээ авчих ийм боломж бүрдэнэ л гэж харж байгаа.

Таны тэр AI-аар оруулаад энэ дээрээс санал, дүгнэлтээ авна гэдэг маань их зөв. Энийг бид нар анхаарч, тэрүүгээр оруулж танилцуулъя. Манайхнаас нэмж ярих зүйл байвал ажлын хэсгээс.

Б.Найдалаа: Рэгдэл гишүүн тодруулж асуух уу. Байхгүй байхгүй юу. Хариулт болсон гэж үзье. Саранчулуун гишүүн асуулт асууна.

О.Саранчулуун: Сайн байна уу. Ажлын хэсэгт баярлалаа. Хуулийн төсөлтэй танилцаж байна. 2 зүйлийг тодруулах гэсэн юм.

Дотуур байрны асуудлууд ерөнхийдөө яаж тусгагдаж байгаа вэ гэдгийг тодруулмаар байна.

2-т гэвэл энэ нөгөө хуулийн хэрэгцээ шаардлагын судалгааны хэсэг дээр хамтарсан багийн ажлын тайлан үзүүлэлтүүд жоохон дурдагдахгүй байгаад байдаг. Гэхдээ нөгөө талд харахаар сэтгэл зүйн асуудал, дээрэлхлийн асуудлыг бас дурдсан байна. Тэгвэл тэр чинь ингээд хамтарсан багийн одоогийн байгаа бүтэц ажиллахгүй байна гэсэн үг үү, эсвэл тэр ажиллах механизм нь бүрдээгүй гэсэн үг үү. Энэ эрүүл сургууль, сургуулийн орчны энэ хуулиар одоо байгаа хамтарсан баг хүүхэд хамгааллын тогтолцооны аль хэсгийг нь засах юм бэ. Аль хүртэл оролцож, аль хүртэл оролцохгүй вэ гэдэг асуудлыг тодруулж өгөхийг хүсэж байна. Судлаачдаас нь.

3 дугаарт нь хэрвээ бид нар бол энэ сургуулийн орчныг бол зөвхөн сургуулийн ийм физик орчин гэж бодохгүй байна л даа. Энэ бол яг хүүхдийн бүр ийм. Well-being буюу сайн сайхан байх ийм орчин байгаа байхгүй юу. Хэрвээ тэр өнцгөөс харвал яагаад гэвэл ДЭМБ-ын зөвлөмж чинь хүүхдийн орчны тухай бүр цогц тийм концепц боловсруулаад танилцуулж байгаа шүү дээ. Хэрвээ тэр зарчмаар ярьж байгаа юм бол энэ өргөн мэдүүлсэн хуулийн төсөл дээр дээрэлхлийнхээ асуудлыг, сургуулийн сэтгэцийн эрүүл мэндийн асуудал зэргээ ямар тогтолцоогоор шийдэх юм бэ гэдгийг эндээс бас харж чадахгүй байгаад байгаа байхгүй юу. Нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, хоол зүйч гээд дурдсан байгаа нь сайшаалтай. Гэхдээ хэрвээ бид нар одоо байгаа хуулиа харах юм бол бүгдэд нь байгаа юм. Дандаа л байгаа. Аюулгүй байдал ч байгаа, орчин ч байгаа. Бүх л хууль дээр байгаа. Тэгэхээр асуудлын гол нь хууль байхгүй байгаад энэ асуудал байгаад байна уу. Эсвэл хуульд байгаа зүйлээ хэрэгжүүлэхтэй холбоотой төсөв, орчин, хүний нөөц болохгүй болоод энэ асуудал гараад байна уу гэдэг 2-ын ялгааг ямар судалгаагаар гаргасан юм бол гэдгийг харчихмаар байгаа байхгүй юу. Хэрвээ үнэхээр хууль байхгүй байгаа юм бол окэй бид нар хуулиараа шийдье. Гэхдээ шийдэх гэж байгаа бол тэр хууль чинь өөрөө тэр яг ДЭМБ-ын санааг авсан шигээ цогц байж чадаж байна уу, үгүй юү гэдэг ийм зарчмын асуудлууд гараад байна л даа. Тэгэхээр энэ дээр ийм 3 асуулт юм уу. Дараа нь тодруулж тайлбар авъя.

Б.Найдалаа: Хариултыг хэнээс асуулаа. Индэр лүү гарна. Нэрээ хэлээд хариулаарай.

О.Чимэдсүрэн: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Судлаач Чимэдсүрэн байна. Саранчулуун гишүүний асуусан асуултад товчхон хариулъя.

2 дахь асуулт. Дотуур байрны хэсгийг бол манай ажлын хэсгээс хуулийн хэд маань хариулчихна. 2-т нь хамтарсан баг байхгүйгээс үүдээд хуульд өөрчлөлт орж байна уу гэдэг тодруулсан судалгааны хэсэг дээр нь би товчхон хариулъя.

Монгол Улсын хэмжээнд өнөөдрийн байдлаар 900-аад ерөнхий боловсролын сургуульд 880-аад суралцагч, 60-аад мянган ажилчид ажиллаж байна. Энэ хүмүүсийн эрүүл сургууль, аюулгүй сургуулийн гол концепц нь тэнд суралцаж байгаа энэ 800 гаруй мянган хүүхдүүд, дээр нь юм мэдээд ажиллагсад, эцэг эх гэдэг энэ уялдаанд нь харсан цогцоор хуулийн өөрчлөлт хийхгүй бол яг өнөөдрийнх шигээ хууль, хуульд жижигхэн жижигхэн тусгачихаар нэгдмэл координат байхгүйгээс өнөөдрийн маш олон асуудлууд тулгамдаад байгаа.

Саяхны Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгийн хийсэн судалгаа манай багийн хийсэн судалгаануудаас ингээд харахад бол суралцагчдын 24 хувь нь ганцаарддаг. Манайд амиа хорлолт хамгийн түгээмэл байдаг. Суралцагчдын нэлээдгүй бараг 15-20 хувь нь амиа хорлох оролдлого хийсэн гэх мэтээр суралцагчдад тулгамдаж байгаа эрүүл мэндийн маш олон асуудлууд хуульчилчихсан хэр нь өнөөдөр ийм байгаад байна. Дээр нь нэмээд эрт илрүүлгийн талаар ерөнхий боловсролын болон сургуулийн өмнөх хуулийн багц өөрчлөлтөд 1 заалт орсон боловч хуулийн хэрэгжилтийг хангах энэ асуудлуудыг хооронд нь уялдуулсан заалтууд байхгүй учраас анхдагч хууль болгох нь зөв юм гэж үзэж байгаа юм.

Саранчулуун гишүүн бас мэдэж байгаа. Монгол Улсад хүүхдүүдийн сурлагын дүн, үзүүлэлтүүд нь бол хүүхэд болгоноор байдаг боловч энэ 800, 900-аад мянган хүүхдийн эрүүл мэндийн нэгдсэн сан байдаггүй. Сургууль дээр эрүүл мэндийн баг ангийн багш, захирал, эрүүл мэндийн багш, сэтгэл зүйч ажиллана гэж байгаа боловч ихэнх сургуулиудад нь мэргэшсэн сэтгэл зүйч, хоол зүйч, эрүүл мэндийн багш, эмч байдаггүй. Бүрэн утгаараа энэ баг ажиллахгүй байгаад байдаг. Бид нар өөрсдөө эрүүл мэндийн салбараас харахад бол голдуу тэтгэвэртээ гарчихсан эмч нар, бага эмч нар сургуулийн орчинд ажилладаг. Тэгэхээр хуульдаа энэ зүйлүүдийг тусгаж өгөөд, координатыг хангаснаараа хүүхдүүдийн дундах өвчлөл буурах юм.

Нөгөө талаараа хүн амын дунд сэргийлж болдог өвчлөлт зайлсхийж болох нас баралтууд давамгайлаад байгаа. Энэ динамикийг өөрчлөхийн тулд хүүхэд үед нь эрүүл, зөв дадалтай иргэнийг төлөвшүүлж байж Монгол Улсын өвчлөлийн динамик өөрчлөгдөх боломжтой. Монгол Улсад 900-аад мянган өрх байдаг. Өрх болгоноос 1 хүүхэд сурч байна. Тэгэхээр бид нар хожимдсон хойно нь эмнэлэг, эмнэлгийн тусламжид биш нийгмийн эрүүл мэндийн тусламж, ялангуяа Монгол Улс шиг сургууль, цэцэрлэгт хамралт өндөртэй орнуудад бол энэ хуулийг цогцоор нь хэрэгжүүлж байж эрүүл мэндэд өөрчлөлт гарна гэж үзэж байгаа. Ерөнхий боловсролын сургуульд ч гэсэн суралцагчийн гол эрх нь бол эрүүл, аюулгүй орчинд байх ёстой гэдгийг манай баг бас хуулийн хэлэлцүүлэг хийж байхдаа хэлэлцэж байсан. Тэгэхээр нарийвчилсан их олон судалгаанууд байгаа. Энэ нөгөө нарийн судалгаануудыг бас түрүүн Рэгдэл гишүүний хэлсэн шиг бид нар нэгтгээд гол гол үзүүлэлтүүдийг оруулчихъя. Ажлын хэсгээс мэдээллээр хангана.

Б.Найдалаа: Саранчулуун гишүүн тодруулж асууна. Индрийн микрофоныг нээгээрэй. Товчхон хариулаарай.

Б.Буянтогтох: Өдрийн мэнд дэвшүүлье. Сургуулийн орчин гэдэг бол нөгөө сургуулийн эргэн тойрны 150 метр талбайг хамарч байгаа орчин байгаа. Тэгэхээр дотуур байрны асуудал бол яг энэ орчин эрүүл мэндийн асуудал нь яг энэ сургууль хамт хамрагдаад явж байгаа гэдгийг хэлье.

Б.Найдалаа: Хэн билээ. Тэмдэглэлд орох учраас нэрээ хэлээрэй. Буянтогтох уу. Саранчулуун гишүүн тодруулж асууна.

О.Саранчулуун: Баярлалаа. Би энэ эрүүл сургуулийн асуудлыг бол яг яагаад энэ хэрэгтэй вэ гэдгийг нь бол би маш сайн ойлгож байна. Бас энэ дээр цогцоор харах хэрэгтэй гэдгийг бас ойлгож байна. Би юуг тодруулах гээд байгаа гэхээр эрүүл сургуулийн талаар одоогийн байдлаар бараг хориод хуульд бол ингээд яг нөгөө энд тэнд эрээвэр хураавар заалтууд тусгачихсан байгаа. Бүгдээрээ харж байгаа. Тэгээд хоорондоо уялддаггүй. Тэгэхээр тэр уялдааг хангасан, хангаж чадаж байгаа гол тэр тогтолцоо юмыг энэ хуулиар өөрчлөх гээд байгаа юм байна гэж тайлбараас ойлгоод

байна л даа. Гэтэл энэ хууль дээр жишээлбэл салбар дундын уялдааг яаж хангах юм ч гэдэг юм уу, нэгдсэн мэдээллийн сан нь ямар байх юм ч гэдэг юм уу, одоо байгаа нийгмийн ажилтан, сэтгэл зүйчдийг ажиллуулж байгаа ямар тогтолцоо дээр түшиглэх юм ч гэдэг юм уу. И-Монголиа гэдэг шиг И-Кидс ч гэдэг юм уу иймэрхүү дундын юм байх юм уу, байхгүй юм уу гэдэг асуудлыг олж харж чадахгүй байгаа учраас тодруулаад байгаа. Дээрээс нь хэрэгжихгүй байгаа хууль байгаад байхад дахиж хууль гаргах хэрэг байдаг уу. Эсвэл байгаа юмаа ажиллуулах талаар хэр хувь нь оролцоотой өөрчлөөд .../минут дуусав/

Б.Найдалаа: Нэмэлт 1 минутыг Саранчулуун гишүүнд.

О.Саранчулуун: Яах вэ, хүүхдийн эрхийн асуудал бол манайд бараг хамгийн их хууль эрх зүй бодлого уялдаа. Төсөв бол хүүхдийн асуудал дээр явдаг. Гол асуудал нь хоорондоо уялддаггүй л юм шиг байгаа юм л даа. Механизм нь ажиллаж өгөхгүй. Сургуулийн нийгмийн ажилтны хийж байгаа ажил, ер нь сургуулийн хамтарсан баг дээр яваад байгаа ажил, сургуулийн сэтгэл зүйч, сургуулийн эмч нарын одоо байгаа түвшнээс ямар ахиц гараад, тэгээд одоо энэ асуудлууд буурах юм бол гэдгийг харчихмаар байгаа байхгүй юу. Тийм өөрчлөлт би эндээс хармаар байгаа. Тэгвэл энэ чинь ингээд нөгөө бид нарын яг бодоод байгаа WHO-н яг Well-being концепцтой ойртохоор юм болов уу л гэж харах гээд байна л даа. Тэрнээс биш ер нь хэрэгтэй гэдгийг ойлгож байна. Маш сайн ойлгож байна. Тийм тэр уялдааг л харах гэсэн юм.

Б.Найдалаа: Индрийн микрофон.

Б.Буянтогтох: Ажлын алба Буянтогтох гишүүний асуултад хариулъя. Ер нь бол салангид хуулиуд бол байгаагаас болоод хэрэгжилт хангалтгүй байгаа нь бид нарын хийсэн судалгаагаар бол хангалттай батлагдсан. Тэгэхээр бид энэ дээр 2 ийм төлөвлөгөөний асуудлыг оруулж ирсэн.

Нэгд бол эрүүл байх төлөвлөгөө. Тэр нь бол сургууль, тэр тухайн захиргааны нэгжид харьяалагдаж байгаа эрүүл мэндийн байгууллагатай хамтраад ерөнхий болон тусгайлсан үзлэгийг хийх, энэ хамтын ажиллагааг хангах тухай нэг асуудал байгаа. Нөгөөдөх нь бол орчны эрүүл мэнд, аюулгүй байдалтай холбоотой бас орон нутгийн засаг захиргааг оролцуулж өгч байгаагаараа нэгдсэн байдлыг илүү хангаж өгч байгаа гэж бодож байгаа юм. Төлөвлөгөө дээр бол илүү нөгөө нарийн зүйлүүд маань тусгагдаад энэ нөгөө хамтарсан нэгдмэл байдлыг хангах энэ асуудлууд энэ төлөвлөгөө рүүгээ илүү нарийн тусаж орж өгөх юм гэдгийг хэлье.

Б.Найдалаа: Баярлалаа. Тодруулга дууссан. Бум-Очир гишүүн асууна.

Д.Бум-Очир: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Юуны өмнө хуулийн төслийг дэмжиж байгаагаа илэрхийлье. Энэ сургуулийн орчны эрүүл мэнд гэдгийг нь ойлгосон. Аюулгүй байдал гэдэг дотор түрүүн хуулийн танилцуулга дотор дээрэлхлийн тухай асуудал дурдагдсан. Гэхдээ яг хуулийн заалтаараа яг хуулийг би амьхандаа хайгаад уншаад байна л даа. Яг дээрэлхлийг зохицуулж байгаа тийм заалт яг хаана нь байгаа юм бол. Тийм заалт бий юу гэдгийг тодруулмаар байна.

Ер нь энэ сургуулийн орчны аюулгүй байдал гэдэг дотор энэ дээрэлхлийн асуудал орох уу. Өөр Хүүхэд хамгааллын хуулиар ч юм уу зохицуулах юм уу гэдэг нэг ийм зүйлийг бодмоор байна.

Тэгээд бид бүгдээрээ мэдэж байгаа. Сая энэ сургуулийн орчмын үе тэнгийн дээрэлхлийн асуудал бол нэлээд их хүнд байдалтай олон мэдээллүүд явсныг бид бүгдээрээ мэдэж байгаа. Тэгээд үүнтэй холбоотой бас жаахан судлаад үзвэл дэлхийн улс орнууд бол дээрэлхлийг хуульдаа томъёолоод оруулчихсан. Тэгээд бүр дээрэлхлийн эсрэг хуультай байна. Жишээ нь АНУ-ын мужууд бол дээрэлхлийн эсрэг хуультай байх жишээтэй. Япон бол дээрэлхлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг дэмжих тухай гэсэн ийм хуультай байна. Филиппин бол дээрэлхлийн эсрэг хууль, Өмнөд Солонгос бол сургууль дахь хүчирхийллээс урьдчилан сэргийлэх болон түүнтэй тэмцэх арга хэмжээний тухай хууль гэх мэтчилний ийм олон хуулиудтай юм байна. Мэдээж яг нийгэм дээр тухайн асуудал хуульд томъёолж оруулж ирэхээс өөр аргагүй тийм тэр хэмжээнд хүрчихвэл хуульд дээрэлхэл гэдэг үгийг бид нар томъёолоод оруулж ирэх шаардлагатай болох болов уу гэж бодож байгаа юм.

Одоогоор миний олж мэдсэнээр бол Монголын хүүхэдтэй холбоотой аль ч хуульд дээрэлхэл гэдэг англиар бол bullying гэж байгаа шүү дээ. Энэ нэр томъёог томъёолсон зүйл байхгүй байгаад байна. Тэгэхээр бид одоо энэ нийгмийн байдлаа хараад дээрэлхэл цаашдаа буурна гэж би бол бас яг үнэнийг хэлэхэд бодохгүй байна л даа. Яг дээрэлхэл гэдгээ хуулийн заалттай болгоод оруулах нөхцөл байдал үүсчихсэн юм болов уу гэж зүгээр би хувьдаа бодож байгаа юм. Тэгэхээр хэрвээ тэгж үзвэл энэ хуульд дээрэлхэл гэдэг нэр томъёог энэ хуулийн эхний хэсэгт нэр томъёонуудаа жагсаачихсан байна л даа. Тэр дотор жишээ нь байхгүй байгаа. Энэ тал дээр өөрсдийн байр суурийг илэрхийлээд өгнө үү гэж хүсэж байна.

Бүр шаардлагатай гэж үзвэл зөвхөн аль нэг хуульд дээрэлхлийг томъёолж оруулахаас гадна бие даасан хуультай улсууд байгаа тухай би бас сая дурдлаа. Тэгэхээр тийм нөхцөл байдал руу бид нар явж байна уу, үгүй юу. Мэдээж сая бас олон гишүүд хэлж байна. Заавал тусдаа хууль байх хэрэгтэй юу, үгүй юу. Тэгэхээр Монголын нөхцөлд бид ер нь яавал дээр юм бэ. Энэ хуульд энэ агуулга орох ёстой юу, үгүй юу гэдгийг бодмоор байна. Шаардлагатай гэвэл би ч бас бодож үзэж л байна. Манай гишүүд бас бодож байгаа байх. Ер нь дээрэлхэхийн эсрэг гэдэг анхдагч хуулийн төсөл барьж орж ирвэл бас зөв ч юм уу гэдгийг л бодоод байна л даа. Энэ тал дээр та бүхэн байр сууриа хуваалцана уу.

Б.Найдалаа: Мөнхсайхан гишүүн хариулна.

Т.Мөнхсайхан: Тэгэхээр ер нь дээрэлхэхийн талаар хүүхэд хамгааллын тухай хууль дээр бас тодорхой зүйл, заалтууд байгаад байгаа. Манай энэ хууль дээр бол 12.3 дээр “сургуулийн захирал, нийгмийн ажилтан, сургуулийн эмч нар нь халдварт өвчин илэрсэн суралцагч болон сургуулийн ажилтныг ялгаварлан гадуурхалт өртөх болон бусад байдлаар эрх нь зөрчигдөхөөс сэргийлэх арга хэмжээ тэр даруйд авна.” гээд. Бид нар ер нь урьдчилан сэргийлэлт ярьж байгаа. Энэ үе тэнгийн дээрэлхэл дээр бид нар бас урьдчилан сэргийлэх бодлого, арга хэмжээнүүд сайн авах ёстой. Өнөөдрийн байдлаар сургуулиуд дээр яг энэ үе тэнгийн дээрэлхлээс яаж сэргийлэх юм бэ. Үүнээс ямар үүдэлтэй, ямар хохирлууд гардаг юм бэ гэдэг талаар мэдээ мэдээлэл өгч байгаа зүйлүүд маш ховор байгаа. Тэгэхээр бид нар энэ хуулийн гол заалт болох энэ эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх баг байх ёстой гэдэг заалт байгаа. Сургуулийн захирлаас авхуулаад нийгмийн ажилтан, хоол зүйч, сэтгэл зүйч гээд 9 хүний бүрэлдэхүүнтэй энэ баг маань төлөвлөгөөгөө гаргаж ажиллах ёстой юм. Урт болон богино хугацааны төлөвлөгөөнүүд гаргаад, энэ дээр нь энэ үе тэнгийн дээрэлхлээс яаж сэргийлэх юм бэ гэдэг энэ төлөвлөгөөгөө боловсруулаад, энийгээ тухайн сум, хороо, аймаг, дүүргийнхээ удирдлага, Засаг

дарга, иргэдийн хуралтайгаа хамтраад хийж хэрэгжүүлэх энэ бодлогыг оруулаад байгаа юм. Энэ төлөвлөгөө хийгээгүй, боловсруулаагүй байж байгаад тухайн сургуулийн орчинд үе тэнгийн дээрэлхлийн асуудал гарах юм бол эргээд хариуцлага тооцох энэ механизмыг л оруулж өгч байгаа. Энэ гол зүйл заалтууд байгаад байгаа юм. Бид нар урьдчилан сэргийлэх арга хэмжээгээ авах. Түүнээс биш яг үе тэнгийн дээрэлхлийн үед ийм ийм арга хэмжээнүүд авна гэдэг тусгайлсан заалтууд бол байхгүй. Цаашдаа ер нь энэ хуулийг хэлэлцэх явцад бас нэмэлтээр оруулж болох байх гэж бодож байна.

Б.Найдалаа: Бум-Очир гишүүн тодруулж асууна.

Д.Бум-Очир: Яах вэ, энэ бол миний л хувийн байр суурь, бодол юм шүү. Баярлалаа хариулт өгсөнд. Дээрэлхэл гэдэг нэр томъёог ер нь энэ хуульдаа яг оруулаад, нэр томъёоны жагсаалт байгаа шүү дээ. Тэр дотор ер нь оруулчихвал яадаг юм бэ. Яагаад би ингэж хэлж байгаа вэ гэхээр нийгэмд бол энэ асуудлыг хүүхдүүд болоод эцэг эхчүүд бүгдээрээ дээрэлхэл гэдэг нэр томъёог хэрэглэж яриад байна. Тэгэхээр бид нар нэгэнтээ нийгэмд энэ нэр томъёо ингээд хуульд байхгүй мөртөө газар аваад яваад байгаа учраас хууль томъёолж байж энэ асуудалтай тэмцэх, энэ асуудлыг цэгцлэх нөхцөл бололцоо нь илүү бүрдэх юм болов уу. Нэгэнтээ дэлхийн бусад орнууд дээрэлхлийн бүр бие даасан дээрэлхлийн эсрэг хуультай байгаа юм чинь бид ядаж нэр томъёог нь оруулж өгснөөр энэ асуудал хүнд шууд буух байх. Би бас хэлний мэргэжлийн хүн учраас тэгж харж байж магадгүй. Дээрэлхэл гэдэг хуулийн нэр томъёо, бие даасан нэр томъёо аль нэг хуульд байх нь энэ асуудалтай тэмцэх маш чухал эхлэл болох болов уу гэж бодож байгаа юм.

Б.Найдалаа: Мөнхсайхан гишүүн.

Т.Мөнхсайхан: Одоо ер нь энийг яг нэр томъёог нь томъёолоод, энэ дээр бас шаардлагатай зүйл заалтуудыг оруулаад явах нь бас цаг үеэ олсон ийм зөв байх болов уу гэж бодож байна. Бум-Очир гишүүнтэй бас санал нэг байна.

Б.Найдалаа: Баярлалаа. Ариунзаяа гишүүн алга байна. Галбадрах гишүүн асуулт асууна.

Ж.Галбадрах: Өдрийн мэнд хүргэе. Энэ бол бас чухал хууль. Ер нь бол энэ сургалтын орчныг бид нар стандарт, норм нормативыг бүрдүүлэх тал дээр л маш их анхаарах хэрэгтэй. Тэгэхдээ тэгээд яг орчин гэдэг дээр энэ эрүүл мэнд аюулгүй байдал талаас нь авч үзээд тэнд мэдээж зөндөө асуудал байна. Энийг маш их урт олон бүлэгтэй, олон зүйлтэй бичсэн байна.

Тэгэхээр миний хувьд бол эхлээд л энэ бүх юмны үүсвэр нь тэр сургуулийн норм нормативыг нь бид нар хангах талаас. Жишээлбэл, сургуулийн барилгыг барихад бол 1 ангид 30-аас доош хүүхэд байхаар ингээд барилгын норм норматив руу барьж байгаа. Цэцэрлэгт бол 20-оос доош хүүхэд байна. Тэгэхээр энэ сургуулийн орчин гэж бид нар яриад байна. Энэ дээр бас цэцэрлэгийг хамтад нь бас авч явах ёстой.

Нөгөө талаас яг тэр стандарт норм норматив талыг нь энэ дээрээ голлож авч үзэж, тэр нөгөө 30-аас дээш давчаад байгаа асуудал. Би бол судалгаа хийж үзсэн. Монгол Улсын өнөөдрийн эдийн засгийнхаа байдлыг харгалзаж үзээд 30-аас доош хүүхэдтэй байна гэдэг стандартыг хангаад явбал хэд болох вэ гэвэл маш өндөр хүүхдүүд тэрийг давчихсан бүлэгт сураад байсан. Тэгэхээр би бол өнөөдөр ядаж

сургалтын энэ 40, 50, 60-д авчхаад байгаа, энийг даваад ирэнгүүт сургалтын чанар алдагдаад байгаа ямар чанартай сургалт явуулах боломжгүй болчихоод байгааг нь үзээд 40-өөс дээших гэдгийг нь аваад л үзэхэд л 30 хувь байгаа юм. Нийт зөвхөн төрийн сургуульд биш шүү. 790-ээд мянган хүүхэд төрийн сургуульд сурч байгаа 850, 860 мянга гэвэл нийт хүүхэд. Би хувийн сургуулийг нь орхиод, зөвхөн улсын буюу төрийн сургуулийг авч үзээд тэр дотроос 40-өөс дээш хүүхэдтэй орчин, тэр 40-өөс дээш хүүхэдтэй орчинд л энэ бүх гараад байгаа тэр үе тэнгийн дээрэлхэл ч гэж ярьж байна. Тэр агааржуулалт ч гэж ярьж байна, дуу чимээ гэж ярьж байна. Энэ бүх зүйл чинь тэр 40-өөс дээших, нормоор бол бүр 30-аас доош байхыг дээш нь үзэхэд ийм байна. Тэгэхээр энэ асуудлаа жишээлбэл 1 дүгээрт энийг шийдэхийн тулд бид нар сургуулийн барилга олноор барья гэхээр улсын төсөвт мөнгө байхгүй гэдэг. Тэгвэл сая бас Ганмаа гишүүн, бас гишүүд бас хэлж байна шүү дээ. Зулпхар гишүүн ч гэсэн бас хэлсэн. Одоо энд ингээд хуульчлаад гараад ирэхээр энэ маань төсөвт жилдээ хэчнээн хэмжээний дарамт ирэх юм бэ. Энэ хууль батлагдсантай холбогдуулаад заавал хэрэгжүүлэх тэр эрүүл мэндийн үзлэгт оруулна гээд явахад хэчнээн зардал шаардлагатай вэ. Тэгээд тэрийг нь орон нутаг, дүүрэг хариуцна гэдэг нь. Тэгвэл бид нар гол зүйл үндсэндээ тэр стандарт, нормоо хангах. Энэ дээр хэрвээ оруулах юм бол би тэр норм норматив, стандарт гэдгийг бүр бичээд байгаа. Барилгын норм талаас нь бас оруулж ирэх нь зайлшгүй чухал байна л гэж. Энийг 1 дүгээрт хэлэх гэсэн юм.

Тэгээд ер нь бол энэ олон хуулийн тэр хэрэгжилт тал дээр нь энийг бүхэлд нь ингээд томоор нь сургалтын орчин гэдгийг авч үзэх талаас нь яаж үзсэн бэ. Эрүүл мэнд, аюулгүй байдал гэдгийг нь.../минут дуусав/

Б.Найдалаа: Индрийн микрофоныг нээе.

Б.Буянтогтох: Гишүүний асуултад хариулъя. Бид зардлын тооцоо хийж үзсэн. Тэгэхээр төрийн байгууллагад үүсэж байгаа нийт зардлын тоо бол 16 тэрбум 200 сая гэж гарч байгаа юм. Ер нь энэ зардалд хамаарах гол зүйл бол энэ сургуулийн орчинд яг эмнэлгийн анхан шатын үйлчилгээ үзүүлэхэд холбоотой шууд зардлууд бас энд хамаарч байгаа. Мөн хүний нөөцтэй холбоотой зардлууд бас гарч байгаа юм. Тэгэхээр тэр тал руу нь орж байгаа. Ер нь бид нар бол ерөнхий болон тусгайлсан 2 үзлэг хийхээр эрүүл мэндийн үзлэг талд нь ийм 2 агуулгыг оруулж өгч байгаа. Тэгэхээр энэ нь болохоор юу гэхээр бид нар анхан шатны эрүүл мэндийн байгууллагад улсаас 1 иргэнээр тооцсон санхүүжилт олгодог. Тэгэхээр тэр анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын бас үндсэн чиг үүрэг дээр ч гэсэн бас энэ эрт илрүүлэг, ерөнхий үзлэг хийх ийм чиг үүрэг байдаг учраас тэндээс зардал нь гарах учраас зардал дээр нэмэлт зардал үүсэхгүй юм гэдэг байдлаар бид нар тооцоогоо хийсэн. Тэр 16 тэрбум төгрөг бол илүү 1 удаагийн шинж чанартай гарах ийм зардлын тоо хэмжээ байгаа. Ийм мэдээлэл өгье.

Б.Найдалаа: Галбадрах гишүүн тодруулж асууна.

Ж.Галбадрах: Энэ маягаар ерөнхийдөө яах вэ 16,7 тэрбумаар тэр эрүүл мэндийн эмчилгээ, үзлэг гэж байна. Тэгээд ер нь тэр үзлэгийг эцэг эхчүүд бас хариуцдаг тэр хариуцлагын тогтолцоонд нь шилжүүлээд бүгдийг нь шүдний үзлэгт оруулах уу гэдэг асуудал байна. Тэгээд нөгөө талаас түрүүн Рэгдэл гишүүн бас их асуусан давхардаж байгаа юм. Сургуулийн орчинд тавигдах шаардлага буюу ялангуяа сургуулийн барилга барихад тэр нөхцөлүүдийг ингээд заачихжээ. Энэ батлагдчихангуут нөгөө арай гэж Улаанбаатарт олж байгаа газрууд маань яг үнэндээ амьдрал дээр бол үнэхээр л Мөнхсайхан гишүүний хэлсэнчлэн их сайхан

том газар олоод сайхан газар тавимаар байгаа юм. Гэхдээ яг олоод гаргаж ирж байгаа нь нөгөө багтаамж хүртээмж нь багасчихсан газар олж өгч байгаа сургууль нь яалт ч үгүй л энэ шаардлагад бол яагаад ч нийцэхгүй. Тэгээд энэ нь эсрэгээрээ нөгөө гох дэгээ болох юм биш байгаа гэдгийг асуумаар байна. Тэр 20 дугаар зүйл байгаад байна шүү дээ.

Б.Найдалаа: Энийг Мөнхсайхан гишүүн хариулна.

Т.Мөнхсайхан: Ер нь одоо шаардлага хангасан газар байтугай, хангаагүй газар олж сургууль барихад Улаанбаатарт хэцүү байна л даа. Тэрийг бид нар маш сайн мэдэж байгаа. Гэхдээ бид нар олдож байгаа дээр нь, болж байгаа дээр нь гэж явсаар байтал өнөөдрийн нөхцөл байдал яг бодит байдал дээр ийм болоод байна. Хүүхдүүд сурч боловсрох ихэнх цагаа өнгөрүүлдэг энэ орчин нөхцөл дээр ирээд юм сурч мэдэх гэж ирээд амь насаараа хохирч байгаа тохиолдлууд цөөнгүй гараад байна. Тэгэхээр бид нар энийгээ хэзээ зогсоож, хэзээ больж, стандарт шаардлага хангасан тийм орчинд сурч боловсрох боломжийг бүрдүүлэх вэ гэдэг асуудал. Тэгээд өнөөдөр үнэхээр нөхцөл байдал хангахад бас хүнд байгаа. Тэгэхээр энэ зүйл заалтууд дээр цаашлаад бас ажлын хэсэг дээрээ яриад бас тодорхой хэмжээний өөрчлөлтүүдийг шаардлагатай бол оруулаад явах нь бас зөв байх гэж ингэж бодож байна.

Б.Найдалаа: Яг сая гишүүдийн асууж байгаа асуулт минийхтэй давхцаж байгаа болохоор нэмээд тодруулаад асуучихвал зөв юм уу гэж бодлоо. Энэ хуулийг юуных нь хувьд дэмжиж байгаа үзэл баримтлалынх нь хувьд хуулийг бол дэмжиж байгаа. Дэмжээд цаашаа хэлэлцэх эсэхийг нь хэлэлцээд явах ёстой гэж үзэж байгаа.

Зүгээр нэг эргэлзэж байгаа, саяын гишүүдийн асуулттай давхцаж байгаа хэдэн зүйл байна. Жишээлбэл тэр хувьсах зардлаас санхүүжүүлнэ гээд 9.15 дээр байгаа юм. Хувьсах зардал одоогийн миний ойлгож байгаагаар энэ зардал ордоггүй. Тэрийг тэгээд Боловсролын яам яг юу гэж бодож байгаа юм. Ер нь зүгээр энэ дээр Боловсролын яам, судлаачид, хувь судлаачид ингээд сая саналуудаа хэлж байна. Боловсролын яам институтийнхээ хувьд ямар байр суурьтай байгаа юм бэ гэдэг нь их чухал байна. Сургуулийн захирал жишээлбэл эрүүл мэндийг хариуцна гээд баахан үүрэг ноогдуулчихсан байна. Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулчихсан байна. Торгохоор болчихсон байна. Дархлаажуулалтыг хариуцах юм байна. Урьдчилан сэргийлэх тэр халдварт өвчнөөс хариуцах юм байна. Вакцинжуулалтыг хариуцах юм байна. Эрүүл мэндийн сайд үнэлгээний тайлангийн аргачлалыг гаргаж өгөөд, тэрнийх нь дагуу тайлагнах юм байна гээд сургуулийн захирал маань яг үндсэн ажлаас гадна ийм нэмэлт юм хариуцах нь л дээ. Уг нь бол ингээд ажиллаж байвал сайн. Тэгээд энийг Боловсролын яам яг юу гэж үзэж байгаа юм бэ. Ямар байр суурьтай, ямар санал өгсөн бэ. Тэрийг хэлээч ээ гэж. Хэрвээ 17 тэрбум төгрөг зарцуулаад иймэрхүү хууль хэрэгжээд явчих юм бол маш сайн. Тэгэхдээ ийм бага зардлаар жоохон эргэлзээтэй санагдаад байна. Би зүгээр яагаад тэгж байна гэхээр энэ хууль ингээд хэрэгжээд явчихвал сайн, зүгээр бодитой, амьдрал дээр хэрэгжихгүй, нөгөө Боловсролын ерөнхий хуульд баахан тэгнэ, ингэнэ гээд хууль заачихсан төсвийг нь тавьж өгөхгүйгээр гацчихсан, эргээд тэр нь хийх ч хэцүү, хийхгүй ч хэцүү ийм заалтууд 1 биш байгаад байгаа. Ялангуяа манай Байнгын хороон дээр. Яг тэр шиг асуудал үүсээд, гоё зөв хууль хэр нь амьдрал дээр хэрэгжихгүй, төсвийг нь тавьж чадахгүй, тэгсэн хэр нь баахан зөрчлийн торгох, шийтгэх баахан үүрэг бие биедээ өгчихсөн болчихвол яах вэ.

Сургууль болгон танхимтай болж таарч байна. Өрөөтэй, тусгай өрөөтэй байна гээд заачихсан байна. Уг нь тийм байвал их сайн байгаад байгаа юм. Зарим сургууль байгаа л байх л даа. Тэгэхдээ түрүүн бас гишүүд хэлж байна. Анги танхимын хүрэлцээнээс авхуулаад наад захын шаардлага юу байгаа билээ. Тэрэнтэйгээ уялдах, амьдрал дээр хэрэгжихдээ яадаг юм бол доо.

Тэгээд асуулт нь Боловсролын яамнаас голчлон асууж байна даа. Боловсролын яам энэ дээр яг ямар байр суурьтай ажилласан юм уу, саналаа өгсөн юм уу, дэмжиж байгаа юм уу, болох юм уу. Ингээд л батлаад л явчих нь байна шүү дээ. Хэн хариулах билээ. Индрийн микрофон.

М.Цогзолмаа: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Боловсролын яамны Ерөнхий боловсролын бодлого зохицуулалтын газрын дарга Цогзолмаа асуултад хариулъя. Сургуулийн орчинд суралцагчийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах тухай хуулийн төсөлд бол Боловсролын яам тодорхой саналуудыг өмнө нь өгсөн байгаа. Ерөнхийдөө өгсөн хуулийн заалт бүр дээр давхардуулсан мөн зарим хуулийн заалтуудтай бас давхардуулсан, бас зөрчилдөж байгаа, түүнчлэн нийцэхгүй байгаа, түүнчлэн бас засаж сайжруулах гэдэг энэ агуулгын хүрээнд бол нэлээн олон саналуудыг бол өгсөн байгаа. Боловсролын салбарт хэрэгжиж байгаа Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль, Хүүхэд хамгааллын хууль гээд, Эрүүл мэндийн тухай хууль гээд холбогдох бас заалтуудад эдгээр хуулийн төсөлд тусгагдсан нэлээдгүй заалтууд маань бас давхардсан агуулгаар нь нэлээн туссан байгаа гэдгийг бол Боловсролын яамныхан бас онцолж хэлье. Тухайлахад, зарим нэг тэр сургуулийн аюулгүй байдал, орчны стандартын жишээлбэл техникийн стандарт, тодорхой техникийн зохицуулалтууд бол бас мөрдөгдөж байгаа.

Мөн сургууль бол өөрөө боловсролын байгууллага. Тэгэхээр бас энэ хуулийн хэрэгжилтийг бас хангах хүрээнд бас боловсролын байгууллагын сургалтын үйл ажиллагаа буюу үндсэн чиг үүрэг бас алдагдах ийм бас эрсдэлүүд үүсэх юм байна. Мөн түүнчлэн бас энэ давхардаж байгаа агуулгууд дээр дахиж хуулийн үр нөлөөний болон бусад хуулиудтай хэрхэн давхцаж байгаа үр нөлөөллийн нөлөөний судалгааг бас дахиж хийх хэрэгтэй байх гэдэг саналыг бол Боловсролын яамнаас өгч байгаа. Бид бас нөгөө яг түрүүнд хэлсэн яг ямар ямар хуулийн заалтууд яаж яаж бас давхацсан байгаа вэ гэдгийг 10 гаруй зүйл заалтаар өгсөн учраас энийг нэг бүрчлэн бас энд унших хэрэггүй байх гэж бодож байна. Ажлын хэсэгт бол бас өгсөн байгаа.

Ерөнхийдөө бол боловсролын салбар буюу Боловсролын яамнаас бол хуулийн төслийг бол ерөнхийдөө дахиж үр нөлөөний судалгааг дахиж хийх, боловсролын байгууллагын, сургалтын байгууллагын үндсэн чиг үүргийг бас алдагдуулах ийм зохицуулалтууд бас нэлээн байгаа. Түүнчлэн эрүүл мэндийн харилцаануудыг зохицуулсан нэлээн заалтууд байгааг бас эргэж харахыг бол хүсэж байгаа. Санал оруулж байгаа. Баярлалаа.

Б.Найдалаа: Баярлалаа. Мөнхсайхан гишүүний микрофон нээе.

Т.Мөнхсайхан: Боловсролын яамнаас бол маш олон удаа, дахин дахин саналуудыг авсан. Саналуудыг тусгаж оруулах шаардлагатайг нь оруулж тусгасан. Энэ дээр маш олон зүйлүүд дээр хариуцлагын асуудал яригдаж байгаа учраас бас ийм сөрөг байр сууриуд байгаад байгаа. Гэхдээ бид нар эрүүл ирээдүйнхээ төлөө бид нар хариуцлагатай байх ёстой. Энийгээ бид нар хуульчлах ёстой гэдэг дээр бол хатуу байр суурьтай байгаа. Тэр хувьсах зардалд эрүүл мэндийн асуудлыг оруулна

гээд Боловсролын тухай хууль дээр сүүлд шинэчлэгдсэн хууль дээр бол орчихсон байгаа. Тэгэхээр угаасаа тэр хууль дээр нь байгаа зүйл. 1 дүгээрт.

2 дугаарт ямар нэгэн байдлаар бид нар энэ сургуульд суурилсан эрт илрүүлэг хийх гэж хаа нэгэн газар нэмж төсөв, нэмэлт зардал гарахгүй. Одоо хийгдэж байгаа ажил. Бид нар сургуульд суурилсан эрт илрүүлэг, хүүхдүүдийнхээ эрүүл мэнд, өвчлөлийг эрт илрүүлж, оношилж, эмчилж байж өнөөдрийн энэ их өвчлөлийг бууруулах нь тодорхой. Тэгэхээр бид нар энэ урьдчилан сэргийлэх үзлэг, эрт илрүүлгээ энэ хүүхдүүд рүүгээ чиглүүлье. Тэгэх юм бол бид нарт эрүүл боловсролтой ирээдүйг бий болгох боломж байна л гэдэг зүйлийг яриад байгаа. Өнөөдөр хийгдэхгүй байгаа зүйлийг хийх гээд байгаа зүйл огтоосоо байхгүй. Хуульчлахгүй болохоор хэн нэгнээс шалтгаалаад явдаг, зогсдог, гацдаг энэ асуудлууд л байгаа учраас энийг хуульчлах нь зөв гэж үзээд байгаа юм.

Би тэгээд энэ зүйл заалтуудаас болоод сургуулийн захирлын үндсэн ажил, чиг үүрэг алдагдах юм биш үү гэдэг асуудлыг би ойлгохгүй байна. Тэр сургуулийн захирлын үндсэн чиг үүргийн гол нэг зүйл бол энэ хүүхдүүдийг эрүүл, аюулгүй орчинд сургах чинь сургуулийн захирал, удирдлагуудын 1 номерын шахуу асуудал байна шүү дээ. Боловсролтой хүүхэд боловсрол эзэмших гэж очоод сургууль дээрээ тахир дутуу болчихсон хүүхэд боловсролтой байгаад ирээдүй нь ямар байх юм. Энэ асуудлыг л ярьж байгаа юм. Тэгэхээр энэ эрүүл мэнд, аюулгүй байдлын зүйлийг маш өндөр түвшинд, эхний эрэмбэд авч үзэх нь захирлын угаасаа үндсэн ажил, үндсэн үүрэг байх ёстой байхгүй юу.

Б.Найдалаа: Баярлалаа. Ойлголоо. Зөв зөв. Хуулийг дэмжих ёстой байх. Зүгээр энэ хэлэлцүүлгийн дараа нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх эсэх нь дэмжигдээд ирсний дараа Байнгын хороон дээр ажлын хэсгээ сайн байгуулаад, саяынхыг маргаангүй болтлоо, нэг санаатай болтлоо сайн хэлэлцмээр байна. Ажлын хэсэг бол нэлээн ачаалалтай, тал талын оролцоог хангаад яг сая Мөнхсайхан гишүүний хэлдгээр бүгдийг нь тэр үзэл баримтлал гэдэг юм уу хуулийн үзэл баримтлал нотлох биз. Тэгээд дараагийн нөгөө зохион байгуулалт хуулийн заалтуудыг жигдэлмээр юм байна. Баярлалаа. Саяынхтай хариулт юм уу. Индэр дээр гараарай. Энэ хооронд Хэрлэн гишүүнийг асуулт асуух гишүүдийн нэрсэнд нэмээдхээрэй. Индрийн микрофоныг нээе.

Д.Дуламсүрэн: Газрын даргынхаа хариулт дээр нэмэлт мэдээлэл өгье гэж бодлоо. Тэр нь юу вэ гэхээр саяын нөгөө гишүүдийн ярьж байгаа юман дээр Мөнхсайхан гишүүний ярьж байгаа сургуулийн орчны аюулгүй байдлыг хангах үнэхээр чухал. Энэ бол хуульчлагдсан юмнууд байгаад байгаа. Гэхдээ гол нь нөгөө бид нарын өгөөд байгаа санал бол юу вэ гэхээр бид нар Боловсролын ерөнхий хууль дээр стандартыг хэрэгжүүлэхтэй холбоотой, ялангуяа норм нормативыг холбогдох салбарын сайд нар хамтран батлахаар ингээд хуульчлагдсан байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ стандартаа яаралтай гаргах хэрэгтэй. Тэгээд дээрээс нь нөгөө стандартын техникийн зохицуулалтаа энэ орчны аюулгүй байдлыг одоогийн байгаа стандартыг бид нар шинэчлэх, техникийн зохицуулалтыг батлах шаардлага байгаад байгаа учраас тэрэндээ энэ орчны аюулгүй байдлын талаар оруулах боломжтой байна гэдэг ийм саналыг өгч байсан.

Санхүүжилттэй холбоотой юман дээр бол Боловсролын ерөнхий хуульд заачихсан байгаа хүүхдийн эрх хамгааллын зардалтай байхаар хуульчлагдсан байгаа анх удаагаа. Тэгэхээр тэр зардал маань өөрөө юунд зарцуулагдах вэ гэхээр ялангуяа хүүхэд хамгааллын мэргэжлийн үйлчилгээ үзүүлэхэд чиглэсэн үйлчилгээ

үзүүлнэ. Тэр нь яг урьдчилан сэргийлэх үйлчилгээнд 50, нөхөн сэргээх хамгаалах үйлчилгээнд 30, шуурхай тусламжийн үйлчилгээнд 20 гэх мэтчилнээр ийм зааврыг нь Боловсролын сайдын тушаалаараа батлуулаад, хэрэгжилтийг хангаж байгаа юм.

Тэгээд дээрээс нь би нөгөө хамгийн гол хэлэх гэж байгаа юм нь боловсролын салбарын чиг үүрэг нь ерөнхийдөө боловсролын үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой хүүхдийг болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах сурч байх хугацаанд нь. Гэтэл энэ дээр нөгөө эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх чиглэлийг маш олон заачихсан. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ гэдгээр явж байгаа. Тэгэхдээ тэр нь өөрөө нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хууль дээр бол өрхийн эрүүл мэндийн төсвийн чиг үүрэгт бүгд байж байгаа асуудал давхацчихсан байна. Тэгэхээр үнэхээр хүүхдийн аюулгүй байдлыг хангах нь чухал. Хүүхэд хамгааллын асуудал нь чухал. Гэхдээ нөгөө хуулиуд дээр давхардсан санаа байгаад байна гэдгийг нь бол түүгээр ингэж гаргаж хэлсэн байгаа.

Дээрээс нь нөгөө багшийн чиг үүрэгтэй холбоотой маш олон асуудлууд бас хуульд орчихсон байгаа. Тэр нь Боловсролын ерөнхий хуулиараа бид нар багшийн чиг үүргийг бол тусгайлан зааж өгөөд, энэ хуульд зааснаас өөр Боловсролын хууль болон тэгээд Хөдөлмөрийн тухай хуулиас зааснаас гадна бусад ажил үүрэг гүйцэтгэхийг хориглоно гээд бас ийм холбогдох заалтуудтай. Тэгэхээр үүнтэй холбоотой юуг бас бодолцож, эргэж үзээсэй гэж байгаа юм. Дархлаажуулалтын тухай хуульдаа одоогоороо бид нар яах вэ Эрүүл мэндийн яамтай манайх сүүлийн 2 жил маш их хамтарч ажиллаж байгаа. Тэр дээр нь эрүүл, аюулгүй сургууль гээд 4 жилийн хугацааны том төлөвлөгөө, Мөнхсайхан гишүүний яриад байгаа төлөвлөгөөг 2 сайд хамтраад баталчихсан байж байгаа. Тэгээд үүнтэй холбоотой эрт илрүүлэг нь бас хийгдээд явагдаж байгаа ийм юмнууд бас байгаад байгаа юм. Тэгээд нэмэлт мэдээлэл болгож өгч байгаа юм. Баярлалаа.

Б.Найдалаа: Баярлалаа ойлголоо. Тийм болохоор хэлэлцэх эсэх шийдэгдэх юм бол, дэмжигдэх юм бол ажлын хэсэг дээрээ энийгээ маш сайн ажиллах, ярих ёстой юм байна шүү. Ганхүлэг гишүүн асуулт асууна.

М.Ганхүлэг: Баярлалаа. Ажлын хэсэг дээрээ эхлээд нэгдсэн ойлголттой болоод орж ирмээр юм биш үү дээ. Жоохон асуудал тойроод байгаа юм шиг л мэдрэмж төрөөд байна л даа. Бие даасан хууль байхын онцлог, шалтгаан юу вэ гэдгийг л ажлын хэсгээс гишүүд асуугаад байна л даа. Тэгээд яг тодорхой кэйс дээр өнөөдөр сургуулийн орчны эрүүл мэндийн асуудал, нормын асуудал дээр яг ийм асуудлыг нь зохицуулж чадахгүй байгаа учраас одоо байгаа хуулиуд нь ийм дутуу байгаа учраас нэмэлтээр ийм хууль орж ирж байна гэдэг талаас нь тодорхой кэйс дээр нэг тайлбарлаж, ойлгуулмаар юм уу. Ерөнхий санааг нь бол ойлгоод байна. Тэгэхээр үнэхээр асуудал шийдэж байгаа бол хэдэн ч удаа хууль хийж болно. Энэ давхардаж байгаа, давхардахгүй байгаа, дахиад ижил агуулгатай байна энэ тэр гэдэг бол яах вэ 1 асуудал. Үнэхээр тодорхой асуудлууд шийдэж чадаж байгаа бол бас болж байна гэсэн ийм саналтай байна.

Тэгэхээр энэ хүүхдийн орчин эрүүл мэндийн асуудалтай холбогдолтой асуудал дээр бол хоол хүнстэй холбогдолтой асуудлыг тусдаа хуулиар зохицуулчихсан гээд тайлбар өгч байх шиг байна. Яах вэ миний хувьд бол тийм дархлаажуулалт, идэвхтэй хөдөлгөөн, тодорхой урьдчилан сэргийлэх энэ тэр гэдэг агуулгуудыг бас илүү сайн дэмжсэн ийм чиглэл рүү бас хуулийн агуулгууд байгаасай. Энэ чиглэлийн юмнууд ямар байна вэ гэдгийг би бас тодруулж асуумаар байгаа юм. Ялангуяа хүүхдийн сүү хөтөлбөр энэ тэр гээд бас тодорхой дархлаажуулалтын гол суурь

зохицуулалтуудыг бусад улсууд энэ тэр хийсэн. Тэрэнтэй адилхан энэ зохицуулалтыг энэ хууль дээр оруулах, хяналт хийх асуудлууд байна уу. Энэ 15 дээр дархлаажуулалтын хяналттай холбогдолтой товчхон хэсэг орсон байх шиг байна.

Мөн дээрээс нь эрүүл чийрэг шинэ үеийг бий болгохын тулд үндсэндээ дасгал хөдөлгөөн, идэвхтэй байх гэдэг бас асуудлыг бол хөндөх нь зөв байх гэж бодож байгаа. Тэгэхдээ энийг бол Хүүхэд хөгжлийн хууль болон бусад хууль руугаа л оруулах юм шиг байна л даа. Тэгэхээр энэ хүнсний асуудал, идэвхтэй дасгал хөдөлгөөний асуудал болон энэ бусад зүйлүүдтэй яаж уялдаж ажиллах вэ. Энийг бас төдийлөн сайн хэрэгжүүлж чадахгүй байгаа энэ дутагдлыг энэ хууль батлагдсанаараа бас сайжруулах, дэмжих бололцоо, нөхцөлүүд байна уу гэдгийг асууя.

Бусдаар энэ Мэргэжил, сургалт, үйлдвэрлэлийн төв, дотуур байр, сургуулийн өмнөх боловсрол, коллеж гээд ерөнхий боловсролын бусад хэсгүүд дээр бас яаж зохицуулалтууд нь орох вэ. Эцэг эх болон аж ахуйн нэгжүүдийн тодорхой оролцоог бас хангасан төсвийн тодорхой асуудлууд орж ирэх юм байна. Энэ дээр нэмэлт ийм зохицуулалтууд байх уу гэдэг иймэрхүү тодорхой асуултуудыг асууя.

Тэгээд яг тийм бодитой жишээн дээр бас энэ хууль байх ёстой юм гэдгийг судалгаан дээр тайлбарласан юм байвал бас их зөв болов уу гэж бодож байна. Хэрэгтэй байна.

Б.Найдалаа: Хариулт. Мөнхсайхан гишүүн.

Т.Мөнхсайхан: Би нэг бодитой амьдрал дээр ганц жишээ дээр 1 тайлбар хэлье. Энэ сум, орон нутгийн сургуулиуд дотор нь ариун цэврийн өрөөгүй сургуулиуд зөндөө байгаа. Гадаа 00-той. Тэгээд энэ дээр өчнөөн хөрөнгө оруулалтууд хийгдэж байгаа. Дотор 00-той болгоод өчнөөн тэрбум төгрөг зарцуулж байгаа. Энэ нь жил ажиллаад л тэгээд тэр нь байхгүй. Дараа жил нь байхгүй. Энэ олон тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт байхгүй. Тэгвэл үүний тогтмол үйл ажиллагааг хариуцаж байгаа. Хэн хариуцлага хүлээж байгаа юм. Сургуулийн захирал, удирдлага хариуцлага хүлээж байгаа юм уу, хүлээхгүй. Сумын орон нутгийн захиргаа хариуцлага хүлээж байгаа зүйл байна уу, байхгүй. Аймгийнх байна уу, байхгүй. Гэтэл энэ хүүхдүүд гадаа 00-д бие засна гэдэг чинь хүүхдүүдийн эрүүл, аюулгүй орчинд сурч боловсрох асар том эрхийг зөрчиж байгаа байхгүй юу. Үүнээс үүдэлтэй маш их өвчний эхлэл уул уурхай болж байгаа. Тэгээд дээрээс нь өчнөөн тэрбумын хөрөнгө оруулалтаар энэ асуудлыг шийдээд байдаг. Гэтэл энийг хариуцаж байгаа хариуцлага хүлээж байгаа хүн байхгүй л байгаад байгаа юм. Гэх мэтчилэн маш олон зүйлүүд энэ дээр байгаа. Ямар нэгэн хуулиудтай тийм айхтар давхцаад зөрчилдөөд байсан зүйл огтоосоо байхгүй.

Одоо өнөөдөр та нар вакцинжуулалт гээд л яриад л байгаа. Томуугийн үед яагаад ингэж их дэгдэлт байдаг юм. Сургуулийн орчинд энэ вакцинжуулалтын асуудал сайн хийгддэггүй шүү дээ. Энэ томуугийн эсрэг арга хэмжээ дээр Боловсролын яам, сургуулиуд идэвхтэй оролцдоггүй байхгүй юу. Оролцоод хамтраад ажиллах юм бол бид нар энэ томууг ийм өндөр түвшинд хүргэхгүйгээр даван туулах боломжтой. Эд нарыг заавал оролцох ёстой. Та нар энэ дээр оролцохгүй бол ямар нэгэн хариуцлага байх ёстой гэдэг зүйлийг бид нар ярьж байж, бид нар амжилтад хүрэх байхгүй юу. Өнөөдөр худлаа тэр нэг хамтарсан тушаал гаргаад, тэр орчин нөхцөлийг бүрдүүлэх, юун хамтарсан урьдчилан сэргийлэх үзлэг.

Тушаал гараад л дараагийн сайд нь ирээд л байхгүй. Хамтын ажиллагаа байхгүй. Тэрнээс болж хэн хохирч байгаа юм. Хүүхэд, залуучууд хохирч байна. Нийгэмд асар их сөрөг нөлөөлөл авчирч байна. Санхүү, эдийн засгийн хувьд ч маш их сэргийлж болох зүйлээс сэргийлж чадахгүй. Ийм л байгаад байгаа юм. Тэгээд үүний эсрэг энийг бас болж байгаа, болохгүй байгаа зүйл их яриад байгаа. Энэ Боловсролын яамны энэ төлөөллүүдийг миний хувьд бол их гайхаж байна. Өөрсдийнх нь ажлыг хөнгөвчлөөд, өөрсдийнх нь ажлыг сайжруулъя гэдэг энэ хуулийг санаачлаад ярихаар болохгүй гэдэг энэ зүйлийг яриад байгаа. Үүний цаана бол том хариуцлагын асуудал яригдаж байгаа учраас ийм байр суурьтай байгаад байгаа гэж миний хувьд харж байгаа.

Түүнээс биш Боловсролын яамнаас санал аваагүй биш. Энэ зөвхөн ганц сар яригдаж байгаа хууль биш, жил дамнан яригдаж байгаа. Би Эрүүл мэндийн сайд байхдаа энэ хуулийн асуудлыг ярьсан. Сургуульд суурилсан эрт илрүүлгүүдийг хүүхдүүдэд яг чиглэсэн илрүүлгийг хийсэн. Маш сайн өндөр үр дүнтэй байсан. Тэгвэл өнөөдөр байхгүй шүү дээ. 6 настны эрт илрүүлгийн үзлэг байхгүй. Хэн хариуцлага хүлээж байгаа юм энэ дээр. Боловсролын яамнаас энийг байхгүй болсонд баярлаж байгаа байхгүй юу. Гэтэл хэдэн мянган хүүхдийг хүнд өвчлөлөөс нь бид нар сэргийлж болоод байгаа байхгүй юу. Энэнд яагаад баярлаад байгаа юм. Тэд нарын ажил нь бага байна шүү дээ. Ажил нь багасчихлаа. Ямар нэгэн хариуцлага хүлээхгүй байна. Бид нар өнөөдөр энэ тогтолцоог өөрчлөхгүйгээр урагшлахгүй шүү дээ. Тэгэхээр одоо жоохон улс орноо бодсон, ирээдүйн хүүхэд залуучуудаа бодсон, ялангуяа иймэрхүү юман дээр хувийнхаа эрх ашиг, хувийнхаа сонирхлыг бодсон биш эрүүл ирээдүй таны хүүхдэд хамаатай хууль ярьж байгаа байхгүй юу.

Б.Найдалаа: Ганхүлэг гишүүн тодруулж асуух уу. Хариулт авсангүй ээ. Индэр дээр.

Д.Нарансүх: Нарансүх судлаач. Бас хуулийн үндэслэл судалгаанаас бас мэдээлэл өгье. 2024 онд хийсэн хүүхдийн орчны эрүүл мэндийн түргэвчилсэн үнэлгээ судалгаан дээр хууль, эрх зүй бодлогын судалгааны хэсэг дээр Боловсролын тухай хуулийн үндсэн зарчим, Боловсролын тухай хуулийн 5.1.5-д “боловсролын байгууллагын хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлэх үйл ажиллагаа сургалт зохион байгуулахыг хориглоно.” Бага, дунд боловсролын тухай хуулийн 4.1.14 дээр “эрүүл ахуйн зохих шатны мэдлэг чадвар эзэмшүүлэх”, суурь боловсролын агуулга 5.1.2 дээр “эрүүл чийрэг болгон төлөвшүүлэх” гэх мэтчилэн боловсролын тухай хуулиуд дээр хүүхдийн эрүүл, аюулгүй байдлын талаар заасан зохицуулалтууд цөөнгүй байна. Мөн 19 Үндэсний стандарт сургуулийн болон цэцэрлэгийн барилгын норм дүрмүүд байгаа боловч яг үүний хэрэгжилтийг яаж хэрэгжүүлэх вэ гэдэг дээр түрүүн бас Чимэдсүрэн судлаач ярьж байсан. Энийг зохицуулсан ийм зохицуулалт бол байхгүй байна гэдэг нь бол судалгаагаар гарч ирсэн. Ер нь бол олон хуульд хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд сургах, өсгөх гэсэн ийм заалтууд байгаа боловч энийгээ зангидсан зохицуулалтууд байхгүй байна.

2024 онд хийсэн энэ эрүүл сургууль цогц үнэлгээний үр дүнгээс харахад энд бол сургуулийн аюулгүй байдал, хоол хүнс, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, эрүүл мэндийн мэдлэг олгох гэх мэтчилэн нийт 817 оноотой Америкийн Си Ди Си болон ДЭМБ-аас хамтарч гаргасан цогц шалгуураар үнэлэхэд нийслэлийн 17 сургууль 817 онооноос дундаж оноо нь 417 оноо авсан. Ерөнхийдөө бусад улс орнуудад тавигддаг эрүүл, аюулгүй сургуулийн ийм шалгуур үзүүлэлт яг бодит

байдал дээр бол манай нийслэлийн сургуулиуд бол хангаж чадахгүй, зөвхөн тал хувийн оноо авч байгаа нь энэ нөгөө Боловсролын тухай хууль тогтоомж дээр хэчнээн ч хүүхдийн аюулгүй, эрүүл орчинд сурч боловсрох талаар заалт, зохицуулалтууд орсон боловч зангидсан ийм нэгдмэл зохицуулалт бол байхгүй байна. Энэ асуудал мөн Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хууль дээр, Эрүүл ахуйн тухай хууль дээр, Эрүүл мэндийн холбогдох хуулиуд дээр ерөнхийдөө эрүүл мэнд гэдэг нийтлэг агуулгаар ороод байгаа боловч хүн амын хамгийн эмзэг бүлэг болох энэ хүүхдийн аюулгүй, эрүүл орчинд өсөж торних энэ асуудлыг зохицуулсан тусгайлсан бие даасан хууль байх зайлшгүй хэрэгцээ шаардлагатай нь бол судалгаануудаар тогтоогдсон.

Б.Найдалаа: Индрийн микрофоныг нээе. Товчхон хариулах бол цаг бага байгаа.

Д.Ганхүрэл: Судалгааны багийн судлаач Ганхүрэл байна. Энэ дээр хууль зүйн талаас нь эрх зүйн талаас тэр нөгөө стандарттай холбоотой давхардал байна уу, үгүй юу гэдэг дээр бол хариулт өгье гэж бодож байна. Одоогоор маш олон тооны стандарт байгаа боловч тухайлбал Боловсролын тухай хууль дээр стандарт батална гэдэг эрхийг нь сайд нарт өгөөд орхичихсон. Хангах, хэрэгжүүлэх механизм байхгүй байгаад байгаа. Тэгээд энэ хуулийн төсөл бол тухайн механизмыг бүрдүүлэхтэй холбоотой урамшуулах болон хариуцлагажуулах тогтолцооны зохицуулалтууд бол бодитоор орж ирж байгаа. Тодорхой 1 кэйс гэх юм бол сургуулийн орчинд хүүхэд нас барсантай холбоотойгоор одоогийн шүүхийн практикийг хараад үзэх юм бол сургуулийн захирал дээр эрүүгийн хэрэг үүсгээд явж байгаа. Болгоомжгүйгээр хүний амь насанд хүрлээ гэдэг байдлаар шүүхийн шийдвэр хүртэл гарчхаад байгаа. Тэгэхээр энэ асуудал дээр ч гэсэн бас захирлын болон сургуулийн эрх ашгийг хамгаалах шинжтэй, тэгэхдээ хамгийн гол концепц сурагчдынхаа эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах үүднээс урьдчилан сэргийлэх тэр хөшүүрэг болж байгаа зохицуулалтууд энэ дээр бол тусгагдаж өгч байгаа.

Тэгээд түрүүний нөгөө үе тэнгийн дээрэлхэлтэй холбоотойгоор энэ хууль маань бол дэмжлэг болж орж ирнэ. Тухайн асуудлыг зохицуулсан үндсэн гол хууль нь бол Хүүхэд хамгааллын тухай хууль байгаа. Гэхдээ одоогоор бас хэрэгжилт нь хангалтгүй байгаа энэ хууль бол сургуулийн орчноор дамжуулаад сурагчдын тэр сэтгэл зүй болон бусад асуудал дээр дэмжлэг үзүүлэх, тэр дээрэлхэл байна уу, үгүй юу гэдэг асуудлыг бас нөгөө сэтгэл зүйч болон тэр эрүүл мэндийн арга зүйчээрээ дамжуулаад бас илрүүлэх ийм боломжууд бас байгаад байгаа.

Манай улсын хувьд гэх юм бол сургуулийн хамрагдалтын хувь маш өндөр байдаг учраас сургуулиар дамжуулаад нөгөө эрүүл, өндөр наслалттай Монгол хүнийг ер нь цогцлооход хамгийн гол тогтолцооны шинжтэй бодлого бол сургуулиар дамжиж явдаг юм байна гэдэг ийм олон улсын судалгаа дээр үндэслэж гарч ирж байгаа юм. Тэгээд эрүүл мэндийн асуудал дээр бол сургуулийн захирал болон сургууль дээр тухайн бүс нутгийн аймаг, дүүргийн эрүүл мэндийн байгууллагууд дэмжлэг үзүүлж оролцохоор байгаад байгаа. Тэгэхээр учиргүй бас захирлуудын, багш нарын ачаалал нэмэгдэх асуудал энд дээр айтгар бол гарахааргүй байгаа.

Аюулгүй байдлын асуудал дээр ч гэсэн тухайн орон нутгийн засаг захиргааны байгууллагууд үндсэн чиг үүргийнхээ хүрээнд тухайн аюулгүй байдалтай холбоотой бас туслалцаа үзүүлэх үүргүүдийг оруулж өгч байгаа учраас бусад хуулийн уялдаа бол энэ дээр хангагдаж гарч ирж байгаа юм.

Хүнсний аюулгүй байдалтай холбоотой асуудал бол Сургуулийн хоол үйлдвэрлэлийн тухай хууль гээд бие даасан, хэдхэн жилийн өмнө батлагдсан нэлээн бас өргөн хүрээний агуулга байгаад байгаа учраас тухайн хуулиар зохицуулагдаад явж байгаа.

Дотуур байрны асуудал бас яригдаад байгаа. Тэгээд сургуулийн орчин гэдэг тодорхойлолтод маань өөрөө дотуур байр маань бас адилхан ороод явж байгаа. Сургуулийн боловсролын барилга гэдэг утгаараа. Тэгэхээр энэ дотуур байр ч гэсэн энэ хууль дээр бол ороод явж байгаа. Тэгээд боловсролын яамны бас саналаар энэ хууль маань уг нь эхэндээ боловсруулагдахдаа ерөнхий боловсролын сургуулиудад зориулагдсан хууль байсан боловч Боловсролын яамны саналаар бас энэ нөгөө өвчлөл болон аюулгүй байдалтай холбоотой асуудал бол энэ мэргэжлийн үйлдвэрлэл МСҮТ гэж ярьдаг. Энэ дээр бас нэлээн яригддаг учраас гээд хүрээ нь МСҮТ ч гэсэн орохоор ингэж тусгагдсан байгаад байгаа. Баярлалаа.

Б.Найдалаа: Ганхүлэг гишүүн тодруулах уу. Болсон уу. Тодруулж асуух юм байна.

М.Ганхүлэг: Асуудлаа жоохон юу өргөн хүрээтэй хараад, тэр дээрэлхлийн асуудал энэ тэр гэдэгтэй адилхан дархлаажуулалт, хоол хүнсний эрүүл ахуй, хүүхдийн сүү хөтөлбөр энэ тэр гээд бид нар бас нэг хийж чадахгүй байгаа асуудлуудыг жоохон хөндөх, дэмжих агуулгууд бас орж ирвэл гэсэн ийм бас саналууд байна. Тиймэрхүү чиглэлээр та хэд судалсан, ажлын хэсэг дээр ярилцсан зүйл байна уу. Хүүхдийн эрүүл мэндийн асуудал дээр бол яг тэр дугуйлан секцүүдийг хичээллүүлэх, идэвхтэй хөдөлгөөн бий болгох, урьдчилан сэргийлэхтэй холбогдолтой асуудлыг бол бас бүрэн дүүрэн шийдэж чадахгүй байгаад байгаа юм.

Тэгэхээр нэгэнтээ л хүүхдүүдээ эрүүл байлгая, аюулгүй орчинд байлгая гэж байгаа ийм асуудлууд бас байгаа учраас эдгээр асуудлуудыг бас дэмжих төрлийн ийм агуулга заалтуудыг яаж нэмж оруулж ирж болох вэ. Энэ дээр бас та хэд судалсан зүйл байна уу гэдгийг ахиад нэг тодруулчихъя.

Б.Найдалаа: Мөнхсайхан гишүүн хариулна.

Т.Мөнхсайхан: Тэр дээр бол судалсан зүйлүүд байгаа. Бид нар яг та бүхний яриад байгаа энэ бусад хуулиудтай давхцуулахгүй, нэн шаардлагатай, өнөөдөр хэрэгцээтэй байгаа энэ зүйл, заалтуудыг л давхардуулахгүйгээр оруулъя гэдэг ийм зарчим баримталсан юм. Жишээ нь, дархлаажуулалтын асуудал ярьж байна. Дархлаажуулалтын тухай хуультай манайх. Тэгэхээр энэ хууль дээр юу байдаг вэ гэхээр дархлаажуулалтад хэн хамрагдах вэ, яаж хамруулах вэ л гэдэг ийм заалтууд байдаг. Дархлаажуулах талаасаа. Тэгвэл жишээ нь заавал дархлаажуулах ёстой энэ дархлаажуулалтад тухайн сургуулийн хамрагдах ёстой хүүхдүүд хамрагдаагүй бол энэ дээр цаашид яаж хамруулдаг болох юм. Энийг бүрэн дүүрэн хамруулахгүй бол тухайн сургуулийн удирдлага, эрүүл мэндийн багууд бас ямар хариуцлага хүлээх ёстой юм гэдэг энэ зүйлүүдийг л бид нар оруулаад байгаа юм. Гэхдээ таны саяын ярьсан зүйлүүд дээр нэмээд ... /минут дуусав/

Б.Найдалаа: Баярлалаа. Болормаа гишүүн асуулт асууна.

Х.Болормаа: Сайн байцгаана уу. Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. Энэ хуулийн төсөл бол үнэхээр бас яг цаг үеэ олсон хуулийн төсөл байна гэж дэмжиж байна. Энэ хуулийн төсөл нь сургуулийн орчныг зөвхөн боловсрол олгодог орчин

биш, харин хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, зөв дадал хэвшлийг хамтад нь хангадаг нэгдсэн ийм систем болгох зорилготой хууль байна гэж харж байна. Өөрөөр хэлбэл хүүхдийн эрүүл мэндийг зөвхөн эмнэлэг хариуцах биш, сургууль өөрөө өдөр тутмын орчиндоо хамгаалдаг байх ийм логик руу шилжиж байна, шилжүүлж байна гэж ойлгож энэ хуулийг дэмжиж байна.

Би уг нь 5 асуулт асуух гээд бэлдсэн боловч манай Байнгын хорооны гишүүд маань ер нь ихэнхийг нь асуучихлаа. Тэгэхээр цагаа хэмнээд 2 асуултыг л би асууя гэж бодож байна.

Энэ хууль хэрэгжихэд ямар хэмжээний зардал шаардлагатай вэ. Энэ дээр түрүүн би өөрөө жоохон буруу ойлгочхов уу. Энэ дээр зардлыг бол ярьж байсан. Тэр 16 тэрбум гэхэв үү. Тэгээд энэ дээр би ахиад нэг тодруулга аваадахъя. Ямар зардал шаардлагатай байгаа вэ. Санхүүжилтийг хэрхэн шийдвэрлэхээр төлөвлөсөн бэ. 5 жилийн дараа ямар бодит үр дүнд хүрсэн, өөрчлөлт гарсан байх вэ гэдэг энэ 2 асуултыг асууя. Бусад асуултууд бол дандаа давхацсан асуулт байгаа учраас цагаа хэмнээд явчихъя даа.

Б.Найдалаа: Хэн хариулах вэ. Индрийн микрофоныг нээе.

Б.Буянтогтох: Гишүүний асуултад хариулъя. Буянтогтох ажлын алба. Хуулийн төсөл хэрэгжиж эхэлснээс яг төрийн өмчийн сургууль, түүний албан хаагчийн хүний нөөцийн цалингийн зардалд 1,5 тэрбум төгрөг, хүний нөөцийн хангамжийн материалд 7 тэрбум 800 сая, тэгээд нийт 9,4 тэрбум төгрөг зарцуулахаар байгаа. Төрийн өмчийн сургуулийн захирлын хүний нөөцийн цалингийн зардалд нийтдээ бол 1,4, хүний нөөцөд нь 250 сая, нийлээд бол 1,7 тэрбум төгрөгийн зардал гарахаар байгаа. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага ба бусад холбогдох төрийн захиргааны байгууллага хүний нөөцийн цалингийн зардалд 22 сая, хүний нөөцийн хангамжийн материалын зардалд 5 тэрбум, нийтдээ 5 тэрбум 26 сая төгрөгийн зардал гарахаар байгаа. Ингээд төрийн байгууллагад үүсэж байгаа нийт зардлын тоо бол 16 тэрбум 201 сая төгрөг гарахаар ингэж тооцоолсон. Ерөнхийдөө бусад эрүүл мэндтэй холбоотой зардлууд бол нөгөө 1 иргэнээр тооцсон эрүүл мэндийн зардал анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудаар гарна. Бид бол энэ сургууль түшиглэсэн эрт илрүүлэг хийснээрээ өвчлөлөөс урьдчилан сэргийлснээрээ бол ирээдүйн нөгөө үр өгөөж маш өндөр гэдгийг бид бол ойлгож байгаа. Тэр утгаараа бид бас түрүүн Ганмаа гишүүний хэлсэн нөгөө 1 долларын зарцуулсан зардлын үр ашиг ирээдүйд гарах нь 40 юм гэдэг агуулгаар бол гаргасан. Бид 6-17 настай хүүхдийгээ бид ерөнхийдөө эрүүл гээд бодчихдог юм байна. Гэхдээ яг амьдрал дээр бол эрүүл биш байгаа нь бид нарын маш олон судалгаагаар харагдаж байгаа. Яг цэргийн насан дээр ирээд л бараг цэргийн насны ихэнх эрчүүд маань эрүүл мэндийн шалтгаанаар хасагддаг. Тийм учраас 3 насны бүлэглэлээр яг тусгайлсан үзлэг хийж байгаа нь эрүүл бие махбодыг эрүүлээр нь урт хугацаанд байлгах нь эдийн засгийн хамгийн үр ашигтай ийм арга хэмжээ юм гэж ойлгож бас энэ сургууль түшиглэсэн үзлэгийн асуудлыг онцгойлж авч үзэж байгаа юм. Баярлалаа.

Б.Найдалаа: Болормаа гишүүн тодруулж асуух уу. Баярлалаа. Хэрлэн гишүүн асуулт асууна.

Б.Хэрлэн: Өдрийн мэнд хүргэе. Тэгэхээр би товчхон 2 зүйл асууя гэж бодож байна. Тэгэхээр энэ хуульд цэцэрлэгийн тухай асуудал, цэцэрлэгийн насны хүүхдүүд хамаарах уу. Сургууль гээд явчхаж байгаа болохоор. Тэгээд зөвхөн

ерөнхий боловсролын сургууль гээд энэ хүрээндээ харчхаж байна уу. Мэргэжлийн боловсролын сургууль, сургууль нэртэй нөгөө дээд сургуулиудын бас оюутан залуучуудын асуудал энд хамаарах уу, хамаарахгүй юу. Энийг 1 дүгээрт асуумаар байна.

2 дугаарт нь ер нь бол энэ хуулийн үзэл баримтлалыг би дэмжиж байгаа л даа. Тэгээд бие бялдрын хувьд, сэтгэл санааны хувьд бас эрүүл саруул хүмүүсийг өсгөж, хүмүүжүүлэе гэсэн ийм санаатай хуулийн төсөл орж ирж байгаад бол би дэмжиж хүлээж авч байгаа. Гэхдээ энэ дээр би нэг концепцын хувьд бас 1, 2 зүйлийг тогтож ярьж гэж бодож байна. Тэгэхээр энэ бол зөвхөн нөгөө бие бялдрын эрүүл мэнд талаас гэхээс илүүтэйгээр бас сэтгэл санааны талын асуудлууд орж ирэх үү. Түрүүн Бум-Очир гишүүний хөндөөд байгаа энэ сургуулийн орчин дахь сэтгэл зүйн дарамтуудын тухай асуудал, тэрнээс хамгаалах тухай асуудал энд орж ирэх үү, үгүй юу гэдэг асуудал байна. Нэгдүгээрх нь.

Хоёрдугаарх нь, яг эрүүл чийрэг бие бялдартаа өсгөж хүмүүжүүлэх тухай дээр бид нар энийг хүүхдэд шим тэжээлтэй хоол өгөх, булчингийн системээ хөгжүүлж спорт тоглоомоор байнга тоглох заалтай биеийн тамирын хичээлийнх нь цаг нь ахиу байх гэх жишээтэйгээр өөрийг нь өөрөөр нь эрүүл чийрэг өсгөж, хүмүүжүүлэх энэ тухай санаа энэ нөхцөлийг бүрдүүлэх тухай зүйлүүд энд орж ирэх үү. Өдрийн хоол, өдрийн цайны хангамжийн тухай асуудал орж ирэх үү. Сургуулийн орчны ариун цэврийн өрөө тасалгааны стандарт тохижилтуудын тухай гээд энэ асуудлууд орж ирэх үү. Яг биеийн эрүүл мэнд талаасаа энэ талын асуудлууд хэрхэн яаж орж ирж байгаа вэ. Эдгээрийг ер нь хооронд нь эрүүл мэндийн үзлэгт ингээд хамруулаад байх, тэгээд энэ биеийн тамирын хичээлийнх нь тухай асуудал, хоол тэжээлийн тухай асуудлуудыг ингээд хамтад нь аваад үзэх юм бол магадгүй нөгөө эрүүл саруул бие бялдартай хүнийг бэлтгэе гээд байгаа энд зорилгод чинь хүрэхэд илүү дөхөм болох байсан уу. Энэ тухай асуудлуудыг цогцоор нь авч үзвэл ямар вэ. Магадгүй зөвхөн ганц эрүүл мэндийн үзлэг дээр бид нар дэндүү төвлөрчихөөрөө бас үйл ажиллагаа чинь эцсийн гол зорилгодоо хүрэх явц чинь арай жаахан өрөөсгөл болчих вий гэсэн ийм бас бодол байгаад байна л даа. Энэ утгаар нь асууж байгаа юм. Тэгээд энэ хуулийг бол би үнэхээрийн дэмжээд байгаа юм.

Одоо тэгэхээр сургуулийн орчинд, цэцэрлэгийн орчинд яваад орохоор чинь хүүхэд ширээнээсээ зүгээр чөлөөтэй босож чадахгүй, яг хавчуулчихсан шпрот шиг ширээ ширээнд нь хавчуулаад, бага насны хүүхдийг чинь шургуулгад хийгээд тавьдаг байсан гэдэг шиг яг тэгж сууж байгаа шүү дээ. Тэгэхээр энэ хууль гараад ирэх юм бол үгүйдээ ядаж сургалтын танхим дахь 1 хүүхдийн нөгөө орон зайн талбайн норм норматив хэмжээнүүд, тэрийг мөрдөх мөрдөх тухай асуудал хүртэл яриг дөх байх л даа. Тэгэхээр эрүүл саруул .../минут дуусав/

Б.Найдалаа: Хариултыг Мөнхсайхан гишүүн.

Т.Мөнхсайхан: Энэ хууль дээр цэцэрлэгийн орчин орохгүй л дээ. Цэцэрлэгийн орчны зохицуулалт нь бас арай өөр байхгүй бол ерөнхий боловсролын сургуулийн хүрээнд яригдаж байгаа. Их, дээд сургуулиуд бас орохгүй. Энэ орчинд хийх зохицуулалтууд маань маш их ялгаатай. Тийм учраас зөвхөн энэ бол 6-17 хүртэлх насны хүүхдүүд сурч боловсорч байгаа ерөнхий боловсролын сургуулийн асуудлыг ярьж байгаа.

Тэгээд энэ дээр эрүүл мэндийн боловсрол олгох гээд энэ хуулийн 14 дүгээр зүйл дээр эрүүл чийрэг бие бялдартай байлгах, эрүүл мэндийн боловсролыг хэрхэн

яаж олгох вэ гээд энэ зүйлүүдийг бүгдийг нь тусгачихсан байгаа. Яах вэ зүгээр та хэдийн нүдэнд энэ урьдчилан сэргийлэх үзлэг нь илүү их тусаад байгаа байх. Энэ бол зөвхөн авч байгаа арга хэмжээний нэгхэн хэсэг. Яг хамгийн гол хэсэг нь энэ бол урьдчилан сэргийлэх үзлэг бол биш юм байгаа юм. Хамгийн гол нь урьдчилан сэргийлэх эрүүл мэндийн .../минут дуусав/

Б.Найдалаа: Хэрлэн гишүүн тодруулж асуух уу. Болсон уу. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Хуулийн төсөл санаачлагчийн илтгэлтэй холбогдуулан үг хэлэх гишүүн байвал нэрсээ өгье. Рэгдэл гишүүнээр тасаллаа. Ганмаа гишүүн үг хэлнэ.

Д.Ганмаа: Хэлэлцэх эсэх асуудал дээр түрүүн Мөнхсайхан гишүүний надад хариулж байсан юман дээр 2, 3 үг нэмээд хэлчихье л гэж бодсон юм.

1 дүгээрт энэ давхардлын талаар 11 хуудас хүснэгтийг сая Байнгын хорооны групп дээр тавьчихсан. Мөнхсайхан гишүүн рүү бас явуулсан байгаа. Сургуулийн орчны эрүүл мэнд, аюулгүй байдлын тухай анхдагч хуулийн төсөл болон түрүүн миний нэрлэсэн хуулиудын давхардал зүйл, заалтыг давхцалтай нь яг хүснэгт хэлбэрээр хооронд нь харьцуулаад гарчихсан байгаа. Энийг ажлын хэсэг харж анхаарч, засаж залруулж яваарай гэж хэлье.

2 дугаарт энэ бодит асуулт нөгөө энэ чинь шинжлэх ухаан, эрүүл мэнд салбар чинь. Тэгээд ийм юм асуухаар урдаас нөгөө хүүхдээ хайрлахгүй юм уу, үр хүүхдэдээ мөнгө зарцуулахгүй юм уу, хүүхдэд л мөнгө зарцуулахгүй бол хэнд зарцуулах гээд байгаа юм гээд ийм хүмүүнлэгийн мораль, ёс зүйд тааруулж хариулахгүйгээр ийм бодитой тоон дээр үндэслэж, ялангуяа эрүүл мэндийн салбарынхан хариулж сурмаар байна. Тэгэхгүй бол энэ манай асуудлыг ер нь ядаж салбарын сайд нар маань тэгж хэлээд яриад сурчихвал манай салбарт их хэрэгтэй болоод байна. Тэгэхлээр түрүүн тэгүүлэхгүйн тулд л би бүр хавдрыг жишээ болгосон шүү дээ. Хавдрын эмнэлэг барьчихаар жилд 4000 хүн нас барахгүй гээд яриад эхлэхгүйн тулд. Яагаад гэхээр энэ чинь шал өөр юм. Эсвэл Си Ди Си байгуулчихвал цэнгэлийн манлай хүрээд, нийгмийн эрүүл мэнд чинь гэнэт сайжирчих юм шиг. Үгүй. Тэгэхээр ийм юм хариулмаар байна. Бодит зардал, үр өгөөжийн харьцаагаа тухайн хуулийн төслийн хүрээнд ямар өвчлөл бууруулах юм, ямар хугацаанд бууруулах юм, ямар нь хамгийн их байгаа юм, тэгэхээр хэдэн хүн хамрагдах юм, ямар хэмжээгээр энэ зардал чинь нарийвчлагдсанд тооцогдох юм гэдэг ийм асуултад хариулмаар байна.

3 дугаарт энэ сургууль дээр суурилсан ерөнхий гол ийм концепц нь манайх би Харвардад байхдаа ч гэсэн 10 мянга гаруй хүүхэдтэй 4 жилийн хугацаатай судалгаа хийж, яг л иймэрхүү ажлуудыг хийж байсан. Энэ бол зайлшгүй хэрэгтэй зүйл байдаг гэдэгтэй санал нэгдэж байгаа. Яагаад гэхээр тэнд зөвхөн эрүүл мэндийн асуудал гэхээсээ илүүтэй нөгөө орчин, сэтгэл зүй, тэгээд нөгөө түрүүн Бум-Очир гишүүний яриад байгаа тэр bullying орчин, тэгээд нөгөө хүчирхийлэл гээд ярих юм бол маш том асуудлууд энд яригдаж гарч ирдэг л дээ. Тэгэхдээ энд миний хэлэх гээд байгаа асуудал нь нэгдсэн мэдээ мэдээллийн дата бэйс, тэрний аюулгүй байдал, хүүхдүүдийн мэдээ мэдээллийн нууцлал, эцэг эхчүүдийн хамрагдалт, энд оролцоо, энийгээ яаж бүр нарийвчилж гаргаж ирэх юм бэ гэдгийг нарийвчилсан суурь параметрээр тодорхой болгож, бүр хуульдаа зайлшгүй тусгах шаардлагатай байна. Бүр бодитойгоор.

3 дугаарт ер нь Боловсролын яамнаас хэлээд байгаа юмыг би бас ойлгож байна. Яагаад гэхээр сая тэр 4 жилийн хугацааны судалгаан дээр харж байхад

нөгөө багш нар маш завгүй, тэгээд 1 анги чинь 50-60 хүүхэдтэй, дундуур нь ороод бид нар юу яахаар зэрэг яг ингээд багш нарын ажил нэмэгддэг байхгүй юу. Тэглээ гээд цалин нэмэгдэхгүй. Хажууд нь нэмэлт support өгөхгүй. Бодит нөхцөл нь байхгүй. Тэгэнгүүтээ хичээл ном заах тэр асуудалд нь бас бид нар яах аргагүй саад тотгор гэх нь хаашаа юм, тэгэхдээ ер нь ажлын ачааллыг нэмэгдүүлдэг. Гэтэл энэ дээр яг бодит санхүүжилт, мөнгө төгрөг, тусламж дэмжлэгийг нь давхар оруулж ирж байж энэ маш сайн үр дүнтэй, үр ашигтай болно гэдгийг анхаарч энэ дээр бүр түрүүлж мөнгө төгрөгийг нь сайн суулгаж өгмөөр байна. Тэгэхгүй түрүүний үр өгөөж дээр хийсэн судалгааг би түрүүн хэлсэн. Зүгээр коэффициентуудыг хооронд нь үржүүлээд гаргачихсан байна. Тэгээд мэдээж энд судлаачид байна. Судлаачид байна, судлаачид байгаа юм чинь та нар чадалтай. Энэ чинь Буянтогтох, манай Чимэдээ багш гээд хүмүүс сууж байна шүү дээ. Тэгэхээр зэрэг бүр нарийвчилсан мэдээ мэдээлэл, тооцоонуудаа бүр сайн гаргаж, ажлын хэсэг дээрээ ажиллаасай гэж хүсэж байна. Ерөнхийдөө тэгээд дэмжье.

Б.Найдалаа: Баярлалаа. Рэгдэл гишүүн үг хэлнэ.

Д.Рэгдэл: Баярлалаа. Хуулийн төслийг бол концепцын хувьд дэмжиж байгаагаа түрүүн хэлчихсэн. Тэгэхдээ бас анхаарах юмнууд нэлээн л байгаа юм шиг байна. Мэдээж хэрэг бид нар үр хүүхэд, ирээдүй хойчийнхоо эрүүл мэнд, аюулгүй байдлын төлөө анхаарч, зардал гаргаж, сайжруулах ёстой. Зүгээр 10 хэдэн тэрбумаар төрийн байгууллагад зардал гаргаж байгаад энэ хуулийг хэрэгжүүлнэ гэдэг бол үндсэндээ худлаа. Энэ бол яах вэ бас иймэрхүү хэмжээний тооцоо хийсэн гэдэг л агуулга явж байгаа байх. Одоо энэ хүүхдийг эрүүл байлгах, эрүүл чигээр нь урт хугацаанд явуулж байгаад сургуулийг нь төгсгөх нь бол хамгийн чухал. Тэгэхдээ энэ чухал асуудлын суурь нь анги дүүргэлт гэж би ойлгоод байгаа юм. 60 хүүхэд суулгачаад, 12 жил хичээллэх гээд үз дээ. Тэр хүүхдийн эрүүл мэнд ер нь яаж муудаж болох вэ. Энийг эмч нар бол маш сайн мэдэж байгаа. Тэгэхээр энэ тал руу нь энэ хуулийн агуулгыг бас хандуулах боломж юу байдаг юм байна анхаараасай гэж бодож байна.

2 дугаарт энэ сургуулийн орчноос шалтгаалдаггүй тэгсэн мөртөө осол аюул гараад байдаг. Өнөө үе тэнгийн дээрэлхэл. Энэ 150 метрийн радиус дотроо болж байгаа энэ үе тэнгийн дээрэлхлээс сэргийлэх ямар боломжууд байж болох вэ. Камержуулалтаас өгсүүлээд. Энэ талаар энэ хуульд бас оруулж өгвөл зүгээр л юм шиг байна.

3 дугаарт энд зүгээр нэг гүйгээд тоолоход бол 6 янзын төлөвлөгөө гарахаар байгаа юм. Тэгээд төлөвлөгөө болгон тайлантай шат шатандаа. Тэгээд 1 баахан цаас болоод явчих вий. Сүүлд нь цаасаар бие биеийгээ хуураад, баахан ажил хийчихсэн, бүтчихсэн гээд явчих вий дээ. Бодитой тусах юмнууд заалтуудаа тодруулах юм байвал их анхаарвал зүгээр байгаа юм.

Тэрнээс гадна 1 л удаа ингээд гүйлгээд л харлаа. Энэ 20 орчим заалт дээр зөв бичгийн дүрмийн алдаа байна. Та нар сайн үзээрэй. Тийм жижиг алдаатай бид нарт ийм төсөл оруулж ирж байгаа явдал бол бас жаахан хайхрамжгүй л хандсаны шинж шүү. Монгол бичгээр бичих зөв бичгийн дүрмийн алдаа 20 орчим байгаа. Тэрийгээ тэгээд өөрснөө олж аваад, дараа дараагийн шатад засаж залруулаад яваарай. Энэ таслалаас өгсүүлээд л явж байгаа. Иймэрхүү анхаармаар юмнууд байна гэдгийг хэлье. Тэгээд эхний хэлэлцүүлэгт орж ирэхдээ бас илүү сайн бэлтгэл тооцоотой орж ирээрэй. Баярлалаа.

Б.Найдалаа: Баярлалаа. Тэгээд сая гишүүдийн ярьж байгаа санаанууд бол нэгтгэх юм бол бүгдээрээ дэмжиж байгаа. Зүгээр яг энэ хуулийн нэрээс нь харсан ч гэсэн сургуулийн орчны эрүүл мэнд, аюулгүй байдлын гээд нэр нь хүртэл нэлээн өргөн байгаад байгаа юм. Тэгэхээр энэ дээр тэр дээрэлхлийг ч дурдаж байна. Хүнсний аюулгүй байдлыг ч дурдаж байна. Цэцэрлэг орох юм уу, үгүй юу гэж тодруулж байна. Ингэхээр юу гэсэн үг вэ гэхээр энэ хэлэлцэх эсэх нь дэмжигдээд явах юм бол ажлын хэсэг өргөн хүрээтэй байгуулаад, яг эдгээр тийм эргэлзээтэй, давхцаж байгаа, давхцаагүй ч юм шиг зүйлсийг нэгтгэх ёстой юм байна. Зарчмын хувьд бол бид нар манай энэ Байнгын хороо дээр ялангуяа гишүүд их яриад байгаа. Эрүүл мэндийн яам, эрүүл мэндийн байгууллага гэхээрээ эрүүл мэнд л хариуцдаг. Сургууль гэхээрээ зөвхөн сургууль хариуцдаг. Цэцэрлэг гэхээрээ зөвхөн цэцэрлэг хариуцдаг. Эцэг эх гэхээрээ зөвхөн хүүхдээ л боддог нэг ийм явцуу салбар дагнасан, чиг үүрэг дагнасан биш, яг хүний төлөөлөл юм бол сургууль нь ч гэсэн дээ эрүүл мэндийн асуудлыг бас хариуцаж болно. Болно гэдгийг бас энэ хуулиар нээх ёстой гэж бодож байна. Харин зүгээр ямар түвшинд нээгээд, тэгээд ямар ч байсан салбараар нь явцуурсан тэр хандлагыг үгүй хийхэд энэ хууль их чухал байна. Чухал байхын тулд бол зүгээр бид нар ярьж байгаад шууд ингээд шийдээд баталчих юм бол болно. Гэхдээ цаана нь хоорондоо сайн ярилцаад, үзэл санаа, тэр үзэл баримтлалыг илүү түгээгээд, яг заалтуудыг нь бас оновчтой болгоод, тэгээд төсөв мөнгийг нь бас алдахгүйгээр тавихуйцаар зохицуулах юм бол энэ хууль амжилттай, бас дээр нь энэ салбар хоорондын яг хүний төлөө, хүүхдийн төлөө зохицуулалт анхдагч хууль болохоор байна. Тийм болохоор зүгээр миний санал бол би нөгөө гишүүнийхээ хувьд саналаа хэлж байгаа шүү. Энэ хуулийг хэлэлцэхийг нь дэмжээд, ажлын хэсгээ чанартай байгуулаад, идэвхтэй ажиллаад, Боловсролын яамныхан бас энэ дээр маш сайн оролцох хэрэгтэй байна. Эрүүл мэндийн яам ч гэсэн. Тэгээд гишүүд оролцоод, саяын хэлснээр сайжруулах юм бол маш хэрэгтэй хууль гэж үзэж байна.

Ингээд гишүүд үг хэлж дууслаа. Одоо Дэгийн тухай хуульд заасны дагуу Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төсөл түүнтэй хамт өргөн мэдүүлсэн төсөл тус бүрийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих эсэх асуудлаар тусад нь санал хураадаг байгаа. Тэгэхээр 4 удаа бид нар санал хураана. Гишүүд санал хураалтад бэлдье. Санал хураалтад бэлдье. Хуруугаа уншуулаарай. Гишүүд анхааралтай байгаарай. Санал хураалт явуулна.

Сургуулийн орчны эрүүл мэнд, аюулгүй байдлын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад оролцсон гишүүдийн 72,2 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Дараагийн санал хураалт.

Хамт өргөн мэдүүлсэн, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Нийт гишүүдийн 72,2 хувь дэмжиж, санал дэмжигдлээ. Энхтуяа гишүүнийг дэмжсэнээр тэмдэглэлд оруулъя.

Дараа нь хамт өргөн мэдүүлсэн, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Нийт гишүүдийн 77,8 хувь дэмжиж, санал дэмжигдлээ.

Дараагийн санал хураалт. Хамт өргөн мэдүүлсэн, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. Санал хураалтад оролцсон гишүүдийн 77,8 хувь дэмжиж, санал дэмжигдлээ.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд танилцуулах ёстой байгаа. Байнгын хорооны санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд танилцуулах гишүүн байна уу. Ганхүлэг гишүүн танилцуулна.

Өнөөдрийн Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны хурлаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

15.33 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ*

Э.СУВД-ЭРДЭНЭ